



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 52.1 ХУВЬТАЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГҮЙЦЭТГЭЛ”**

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/05-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkboldd@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Баярмаа

Утас: 261639 Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Наранжаргал

Утас: 262451 Цахим хаяг: naranjargalm@audit.gov.mn

Аудитор: Н.Хандмаа

Г.Сарангоо

Н.Уртнасан

М.Баяртогтох

Б.Буянхишиг

Б.Бүрэнхүү



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Н.Учрал), Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Өнөрбаяр), төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.


Д.ЗАГДЖАВ

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\0313 GNAG-2.Docx

1525010097

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 03 дугаар сарын 13-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт
А/20



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Албан шаардлагын товч утга	Албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	ТНБД С.Жавхланбаатар	Зөрчил арилгуулах тухай	-

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн жагсаалт.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл.....	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ 1. УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХАД ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГААГҮЙ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙГ УЛСЫН ТӨСӨВТ БҮРЭН ТУСГААГҮЙ БАЙНА.....	8
Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 47 зорилт, 234 үйл ажиллагаанаас Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд 22 зорилтын 34 үйл ажиллагаа тусгагдсан байна.....	8
Богино хугацааны баримт бичгийг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан байх зарчмыг бүрэн хангаагүй, олон нийт санал өгөх боломжийг бүрдүүлээгүй байна.....	9
Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоолоогүй 43, ТЭЗҮ, зураг төсөвгүй 26 ТАХ-а тусгасан байна	9
ХБТТУТХ-д заасан “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна	10
Хариуцагч байгууллагууд эрсдэлийг удирдаж чадахгүй байна.....	11
Эрхэлсэн салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, журам боловсруулсан ч тухайн салбарын шалгуур үзүүлэлт, индексийг тооцож бодлогын хэрэгжилтэд үнэн зөв хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зохицуулалт орхигдсон байна	11
ҮСХ-оос Улсын хэмжээний жилийн статистик тоон мэдээллийг харилцан адилгүй хугацааны давтамжтай тархааж байгаа нь бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг зөв тооцох боломжгүй байна	12
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЗАРИМ ТООН МЭДЭЭЛЭЛ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ГАРГАХ ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА БОЛООГҮЙГЭЭС 3 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙД ХҮРЧ 5 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 68.8 ХУВЬТАЙ БАЙНА.....	15
НЭГ. ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	15
ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	17
ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	21
ДӨРӨВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ.....	24
ТАВ. ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	26
ЗУРГАА. УЛААНБААТАР ХОТЫН ТҮГЖРЭЛ, АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	28
ДОЛОО. ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ..	31
НАЙМ. НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	32
ДҮГНЭЛТ: 44	
ЗӨВЛӨМЖ: 45	
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	47
Үндэсний аудитын газрын тайлбар:	49
Хавсралтууд	50-81

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГЗТ	Гадаадын зээл, тусламж
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДМАЭМБ	Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
МБ	Монголбанк
МУИХХШТХ	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль
МУХТЖҮЧ	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБАНТХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТХХТТ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв
ТХХТТХ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал

УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам
УХЖТ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ШСАА /ГХХОАХ/	Шадар сайдын ажлын алба /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/
ШСАА /ОБАЭ/	Шадар сайдын ажлын алба /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/
ШТА	Шууд тайлагнах ажил
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн нэгтгэл	7
Хүснэгт 2 Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан мэдээллийн харьцуулалт	8
Хүснэгт 3 МУХТЖҮЧ-ийн зорилт, үйл ажиллагааг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй байдлын судалгаа	8
Хүснэгт 4 ТЭЗҮ, зураг төсөл шаардлагатай ТАХ-ний судалгаа.....	9
Хүснэгт 5. УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний шаардлагатай хөрөнгийн дүн, эх үүсвэрийн нэгтгэл.....	10
Хүснэгт 6. Төсвийн тухай хуульд батлагдсан ТАХ-ний задаргаа	10
Хүснэгт 7. УХЖТ-нд тусгагдсан 8 тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн санхүүжилтийн дүн	11
Хүснэгт 8. Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл	15
Хүснэгт 9 Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл.....	15
Хүснэгт 10 “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн	18
Хүснэгт 11. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн ТАХ-ний үр дүн	18
Хүснэгт 12. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл.....	21
Хүснэгт 13 “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл	21
Хүснэгт 14. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл.....	24
Хүснэгт 15 “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл.....	24
Хүснэгт 16 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөрийн үр дүн.....	27
Хүснэгт 17 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн.....	27
Хүснэгт 18. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн	28
Хүснэгт 19 Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн.....	29
Хүснэгт 20 “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөрийн үр дүн.....	31
Хүснэгт 21 “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн	31

Хүснэгт 22 “Байгаль орчны гүйцэтгэлийн индекс”-ийн үндсэн 3 ангиллын үзүүлэлт	32
Хүснэгт 23 Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн	32
Хүснэгт 24 Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн	32
Хүснэгт 25. Аудитаар өгсөн зөвлөмжийн мэдээлэл	37
Хүснэгт 26. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн мэдээлэл	38
Хүснэгт 27. Агаарын чанарын стандарт хүлцэх агууламж, сарын дундаж мкг/м3	42

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1. Хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн	12
Дүрслэл 2. УХЖТ-г боловсруулж, батлуулах хугацаа	12
Дүрслэл 3. УХЖТ-ний хэрэгжилт үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах хугацаа	13
Дүрслэл 4. Экспортын хэмжээ	15
Дүрслэл 5. Ачаа эргэлт	16
Дүрслэл 6. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	18
Дүрслэл 7. Эрчим хүчний түгээлтэд эзлэх хувь	19
Дүрслэл 8. Хотын хөгжлийн ерөнхий индекс, дэд бүлгээр	28
Дүрслэл 9. УХЖТ-нд тусгагдсан Тэргүүлэх чиглэлийн хүрээнд зарцуулсан ТАХ-ний гүйцэтгэл тэрбум.төгрөг	34
Дүрслэл 10. Нийт зарцуулсан хөрөнгийн тайлагналын зөрүү	35
Дүрслэл 11. УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний хөрөнгийн зарцуулалт	35
Дүрслэл 12. Зөвлөмжөөр өгсөн зөрчил аудитаар давтан гарсан талаарх мэдээлэл	38
Дүрслэл 13. Гадаад худалдааны нийт эргэлт дэх экспортын хэмжээ	39
Дүрслэл 14. Уул уурхайн салбар, боловсруулах үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь	40
Дүрслэл 15. Хотын хөгжлийн үзүүлэлт	42

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Тэргүүлэх чиглэлийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл	1
Хавсралт 2. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл	2
Хавсралт 3. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Хөтөлбөрийн үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл	5
Хавсралт 4. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Төсөл, арга хэмжээний үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл	11
Хавсралт 5. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн тайлагналын нэгтгэлийн судалгаа	30

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт аудит хийж Улсын Их Хуралд танилцуулах” гэж заасан чиг үүргийг үндэслэн гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Монгол Улсын Хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахад дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөг үндэслэлтэй, дунд хугацааны баримт бичигтэй уялдуулан олон талын оролцоог хангаж төлөвлөсөн эсэх;
- Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байж дунд хугацааны бодлогын зорилтыг хангахад чиглэгдсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө” баримт бичигт тусгасан Тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг хариуцан хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах үүрэгтэй байгууллагууд, улсын хэмжээнд бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, үнэлж дүгнэх ЗГХХГ, 22 төрийн захиргааны төв байгууллага, 6 агентлаг, холбогдох 2 байгууллага, 2 ажлын албад зэрэг шалгагдагч болон хамрагдагч этгээдийн 2024 оны жилийн үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэл, нийцлийн аудитын стандарт АДБОУС 3000, АДБОУС 4000, Монгол Улсын төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 “Төрийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөлтийн санал, бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээ баримт зэрэг холбогдох материалыг шалгах, үндсэн хариуцагч байгууллагын асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын дүн тайланд шинжилгээ, харьцуулалт хийж аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

Хууль:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.72 дахь заалт; /1992 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /2024/
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль; /1993 он/
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль /2023 он/
- Төсвийн тухай хууль /2011 он/
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль/2010 он/

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль /2023 он/
- Өрийн удирдлагын тухай хууль /2015 он/
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /2003 он/
- Шилэн дансны тухай хууль /2014 он/
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /2021 он/

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”,

Засгийн газрын тогтоол

- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”,
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;

УИХ-ын тогтоол болон Засгийн газрын тогтоолоор баталсан төрөөс баримтлах салбарын бодлого, үндэсний хөтөлбөр, бусад эрхийн актууд;

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Баярмаа хэрэгжүүлж, ахлах аудитор М.Наранжаргал, аудитор М.Баяртогтох, Б.Буянхишиг, Г.Сарангоо, Н.Уртнасан, Н.Хандмаа, Б.Бүрэнхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолд “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 8 Тэргүүлэх чиглэл, 24 ТЕЗ, 53 хөтөлбөр, 194 ТАХ-ний үр дүнд нийт 306 шалгуур үзүүлэлтээр 2024 оны зорилтот түвшнийг тусгаж, нийт 185 ТАХ-нд 13,994.7 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэж тусгажээ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн дүнг дараах 8 тэргүүлэх чиглэл тус бүрээр баталсан байна. Үүнд:

Хүснэгт 1. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт, шаардлагатай хөрөнгийн нэгтгэл

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Шаардлагатай хөрөнгийн дүн /тэрбум.төгрөг/
1.	Экспортыг нэмэгдүүлнэ	Экспорт	Тэрбум ам.доллар	2022	12.5	13.7	2,737.2
2.	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	Гадаадын хөрөнгө	Тэрбум ам.доллар	2021	2.7	4	5,847.4
3.	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна	Хүний хөгжлийн үзүүлэлт	Эрэмбэ	2021	96	92	561.9
4.	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ	Хүлээн авах гадаад жуулчид	Тоо (сая)	2022	0.3	1.3	801.4
5.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна	Хүнсний аюулгүй байдлын индекс	Хувь	2021			174.9
6.	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна	Хотын хөгжлийн үзүүлэлт	Оноо	2021	0.6	0.6	3,761.2
7.	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	Эрэмбэ	2021	108	100	100.5
8.	Ногоон хөгжлийг дэмжинэ	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	2022	155	130	10.1

Эх сурвалж: УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоол

БҮЛЭГ 1. УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХАД ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГААГҮЙ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙГ УЛСЫН ТӨСӨВТ БҮРЭН ТУСГААГҮЙ БАЙНА

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 47 зорилт, 234 үйл ажиллагаанаас Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд 22 зорилтын 34 үйл ажиллагаа тусгагдсан байна

1.1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд шалгуур үзүүлэлт бүрээр бодлогын хэрэгжилт, үр дүнг тайлагнах, үнэлж дүгнэхээр төлөвлөсөн нь өмнөх онуудын богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгээс тодорхой ахицыг бий болгосон байна.

1.2. ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.13, 9 дүгээр зүйлийн 9.2.6-д зааснаар УХЖТ-г МУХТЖҮЧ-тэй нийцүүлэн батлуулахаар заасан байна. Аудитын явцад УХЖТ нь МУХТЖҮЧ-тэй нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

1.3. МУХТЖҮЧ-ийн 9 бодлого, 9 зорилгоос 8 нь тус тус улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байна. Мөн МУХТЖҮЧ-ийн 47 зорилтоос 22 нь, 234 үйл ажиллагаанаас 34 нь УХЖТ-нд тусгагдсан байна.

Хүснэгт 2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан мэдээллийн харьцуулалт /тоо/

МУХТЖҮЧ-д тусгагдсан		УХЖТ-тэй	
		Тусгагдсан	тусгагдаагүй
Бодлого	9	8	1
Зорилго	9	8	1
Зорилт	47	22	25
Үйл ажиллагаа	234	34 ¹	200

Эх сурвалж: УИХ-ын 2020.08.28-ны 23 дугаар тогтоол, УИХ-ын 2023.05.30-ны 39 дүгээр тогтоол

1.4. МУХТЖҮЧ-ийн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” бодлого УХЖТ-нд тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, 2024 онд дээрх бодлого, түүнд хамаарах зорилго болох үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

1.5. МУХТЖҮЧ-ийн зорилт, үйл ажиллагаа Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан талаар судалгаа хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 3 МУХТЖҮЧ-ийн зорилт, үйл ажиллагааг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй байдлын судалгаа /тоо/

Бодлогын чиглэл	Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй	
	Зорилтын тоо	Үйл ажиллагааны тоо
Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	16
Хоёр. Хүний хөгжил	5	47
Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга	5	24
Дөрөв. Эдийн засаг	1	26
Тав. Засаглал	4	23
Зургаа. Ногоон хөгжил	3	40
Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм	2	20
Найм. Бүс, орон нутгийн хөгжил		21
Ес. Улаанбаатар ба дагуул хот	3	19

Эх сурвалж: УИХ-ын 2020.08.28-ны 23 дугаар тогтоол, УИХ-ын 2023.05.30-ны 39 дүгээр тогтоол

¹ Давхардсан тоогоор

1.6. МУХТЖҮЧ-д тусгагдсан зорилт, үйл ажиллагааны ихэнх нь Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдахгүй байгаа нь логик уялдаатай, системтэй төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгээр дунд хугацааны бодлогын зорилт, үйл ажиллагааны үр нөлөө, ахицыг бүрэн үнэлэх боломжгүйгээр төлөвлөгдөж байна.

Богино хугацааны баримт бичгийг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан байх зарчмыг бүрэн хангаагүй, олон нийт санал өгөх боломжийг бүрдүүлээгүй байна

1.7. ХБТТУТХ-ийн зарчим 5.2.13-т “бүх талын оролцоог хангасан байх зарчим” ..., 9.6.3-т “...төрийн болон төрийн бус байгууллага ...оролцоог ханган боловсруулсан байх” гэж заасан байна.

- УХЖТ-нд тусгах ТАХ-ний санал боловсруулан ЭЗХЯ-д нийт 18 ТЕЗ нар хүргүүлсэн байна. Тус саналыг боловсруулахдаа бүх талын оролцоог хангасан байх зарчмыг хангасан 8 ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээний 57 байгууллага, 3 эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас саналыг албан бичгээр болон цахим хэлбэрээр авсан байна.
- Харин бүх талын оролцоог хангасан байх зарчмыг хангаагүй 10 ТЕЗ нар байна.

1.8. ЭЗХЯ нь өөрийн хамаарах чиг үүргийн хүрээнд ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.7² дахь заалт хэрэгжих боломж бүрдүүлээгүй байна. Тухайлбал:

- 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр төлөвлөгөөний төслийг өөрийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан ч төсөлд иргэд, олон нийт санал өгөх боломжийг бүрдүүлээгүй, зөвхөн танилцах хэлбэрээр байршуулсан байна.

Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоолоогүй 43, ТЭЗҮ, зураг төсөвгүй 26 ТАХ-г тусгасан байна

1.9. ХБТТУТХ-ийн 6.10.2³-т ...шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, ...техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, ...байх” гэж заасан байна.

1.10. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд туссан 205 шалгуур үзүүлэлт бүхий, 194 ТАХ-ээс ТЭЗҮ, зураг төсөл шаардлагатай 122 ТАХ байна.

Хүснэгт 4 ТЭЗҮ, зураг төсөл шаардлагатай ТАХ-ний судалгаа

ТАХ-ний тоо	Үүнээс	
	ТЭЗҮ, зураг төсөвтэй	ТЭЗҮ, зураг төсөвгүй
122	96	26

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

1.11. ТЕЗ нар ХБТТУТХ-ийн 9.6.1.-т “... 4.1.13⁴-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, ...өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох”, 9.6.2.-т “... бичигт тусгах саналаа⁵ ... хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх” гэж заасны дагуу УХЖТ-нд саналаа хүргүүлсэн байна.

1.12. УИХ-ын харьяа 12 байгууллага, 21 яам, агентлаг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгах төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөр, ТАХ-ний саналаа хуулийн хугацаандаа хүргүүлсэн байна. Тухайлбал:

- Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд туссан нийт төсөл, арга хэмжээний 78 хувийг ТЕЗ-ийн саналд үндэслэсэн байна.

2. 9.4.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох төрийн байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх;

3. ХБТТУТХ-ийн 6.10.2.санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх;

4. ХБТТУТХ-ийн 9.6.1. энэ хуулийн ... 4.1.13-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох;

5. ХБТТУТХ-ийн 9.6.2.энэ хуулийн 9.6.1-д заасан баримт бичигт тусгах саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, төлөвлөхөд шаардлагатай өөрийн эрхлэх асуудлын хүрээний тоо баримт, судалгаа, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх;

- о ТЕЗ-ийн саналд үндэслээгүй 43 ТАХ хэмжээг УИХ-ын хуралдаанаас УУХҮС, ЗТХС нарт 5, Засгийн газрын хуралдаанаас БСҮХС, Сангийн сайдын хамтарсан 1, ЭЗХЯ-ны саналаар ЗТХС, ГХС, УУХҮС, БХБС, Соёлын сайд, БШУС, ХНХС, НЗД, ЭХС нарт 36 ТАХ-г тус тус хариуцан хэрэгжүүлэхээр хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан байна.

1.13. Богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж боловсруулах үүрэгтэй зарим ТЕЗ, ЭЗХЯ нь ХБТТУТХ-д заасан “бүх талын оролцоог хангах” зарчмыг баримтлаагүй, зарим төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөлгүй, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг оновчтой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилж тооцоогүй зөрчлүүд давтагдан гарч байгаагаас бодлогын хэрэгжилт зорилтот үр дүнд хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

ХБТТУТХ-д заасан “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна

1.14. УХЖТ-нд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээнээс 185 ТАХ нь санхүүжилтийн дүнтэй, 9 ТАХ нь хөрөнгийн дүн болон эх үүсвэргүй тусгагдсан байна. Харин 30 ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон ч шаардлагатай хөрөнгийн хэмжээг тусгаагүй байна.

1.15. Санхүүжилтийн дүн тусгагдсан 185 ТАХ-г УХЖТ-нд тусгагдсан байдлыг ангилж доор үзүүлэв.

Хүснэгт 5. УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний шаардлагатай хөрөнгийн дүн, эх үүсвэрийн нэгтгэл

/тэрбум.төгрөг/

Эх үүсвэр	Улсын болон ОНТ	Гадаадын зээл, тусламж	Гадаад, дотоодын ХО	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Бусад эх үүсвэр	Нийт дүн
ТАХ тоо	115	23	9	17	21	185
Мөнгөн дүн	2,323.6	1,386.9	3,436.0	4,520.8	2,327.4	13,994.7

Эх сурвалж: УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө

1.16. Аудитын баг УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний санхүүжилтийн дүнг 2024 оны Улсын төсөвт хэрхэн батлагдсан талаар судалгаа хийв. УХЖТ-нд Улсын төсвийн болон бусад төрлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх 185 ТАХ-ээс 34 ТАХ-ний 1,067.6 тэрбум төгрөгийн санхүүжилт улсын төсөвт тусгагдсан байна. Харин Улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан боловч 2024 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй 151 ТАХ үлдсэн нь ХБТТУТХ-нд заасан 9.5.3⁶ “... тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж ...” гэсэн заалттай нийцээгүй байна.

1.17. УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай уялдсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Төсвийн тухай хуульд батлагдсан ТАХ-ний задаргаа

/тэрбум төгрөг/

Нийт 2024 оны Улсын төсөвт тусгагдсан			Улсын төсвийн эх үүсвэртэй ТАХ-ээс Улсын төсөвт тусгагдсан		Бусад төрлийн эх үүсвэртэй ТАХ-ээс Улсын төсөвт тусгагдсан	
ТАХ-ний тоо	Төсөв	Төсвийн тодотгол	ТАХ-ний тоо	Төсөв	ТАХ-ний тоо	Төсөв
34	1,099.3	1,067.6	29	923.6	5	144.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

1.18. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Экспортыг нэмэгдүүлнэ”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна”, “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлүүдэд хамаарах 36 ТАХ-ний 11 нь Улсын төсвөөс санхүүжихээр батлагдсан боловч 2024 оны Улсын төсөвт тусгагдаагүй байна.

6 ХБТТУТХ-ийн 9.5.3 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах гэж заасан байна.

Хүснэгт 7. УХЖТ-нд тусгагдсан 8 тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн санхүүжилтийн дүн /тэрбум төгрөг/

№	Тэргүүлэх чиглэлийн нэр	Монгол Улсын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан				Монгол Улсын 2024 оны төсөвт батлагдсан	
		ТЕЗ-ийн үр дүн	хөтөлбөрийн үр дүн	ТАХ	санхүүжих дүн	ТАХ	санхүүжих дүн
1	Экспортыг нэмэгдүүлнэ	4	6	23	2,737.2	0	-
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	5	11	52	5,847.4	9	97.6
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна	3	11	28	561.9	7	701.6
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ	3	3	35	801.4	13	167.0
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна	1	1	5	174.9		
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна	2	7	23	3,761.2	4	99.6
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна	5	10	20	100.5	1	1.8
8	Ногоон хөгжлийг дэмжинэ	1	4	8	101	0	-
Нийт		24	53	194	13,994.7	34	1,067.6

Эх сурвалж: 2024 оны УХЖТ болон Улсын төсвийн тухай хууль

1.19. Төсвийн тухай хуулийн 27.1.8⁷д заасан “УХЖТ-нд суурилсан байх” шаардлага бүрэн хангагдаагүйгээс УХЖТ-нд “Улсын төсөв” эх үүсвэртэй тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд зорилтот үр дүнд хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Хариуцагч байгууллагууд эрсдэлийг удирдаж чадахгүй байна

1.20. ХБТТУТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “... хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд ...бий болох үр нөлөө, **эрсдэл**, ...тусгана” гэж заасан шаардлагыг хариуцагч байгууллагууд бүрэн хэрэгжүүлээгүй байна. Харин дараах байгууллагууд эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- Батлан хамгаалах яам “Эрсдэлийн удирдлага, зохицуулалтын арга зүйн заавар”-ыг боловсруулсан;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам “Эрсдэлийн удирдлагын бодлого, дүрэм, журам, гарын авлага”-ыг боловсруулсан
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам эрсдэлийн удирдлагын үнэлгээ хийсэн;

1.21. Эрсдэлийг удирдах төлөвлөгөөг боловсруулаагүйгээс тухайн төсөл, арга хэмжээ төлөвлөгөөний дагуу зорилтот түвшинд хүрэхгүй байх, цаашлаад Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө биелэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Эрхэлсэн салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, журам боловсруулсан ч тухайн салбарын шалгуур үзүүлэлт, индексийг тооцож бодлогын хэрэгжилтэд үнэн зөв хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зохицуулалт орхигдсон байна

1.22. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөр, ТАХ-ний гүйцэтгэлд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж тайлагнасан 28 төсвийн ерөнхийлөн захирагч нараас ерөнхий чиг үүргийн 3 яам, чиглэлийн 8 яам, 1 агентлаг “Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2-т заасны дагуу⁸ эрхэлсэн

7 27.1.8.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлага

8. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2-д “Энэ журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай” гэж заасан байна.

салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг нийтлэг журамд үндэслэн боловсруулсан байна.

1.23. Гэвч дээр агентлаг, яамдын боловсруулсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалд дүн шинжилгээ хийхэд тухайн салбарын онцлог, салбарын хэмжээний шалгуур үзүүлэлт, индекс, гүйцэтгэлийн чанарын стандартыг хэрхэн тооцож бодлогын хэрэгжилтэд үнэн зөв хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зохицуулалт тусгаагүй байна. Энэ нь нийтээр дагаж мөрдөх журмын зохицуулалтаас ялгагдах зүйлгүй байна. Тухайлбал:

Дүрслэл 1 Хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” тэргүүлэх чиглэлийн зорилтыг үнэлэх
Хүнсний аюулгүй байдлын асуудал нь аливаа улс гүрний үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байдаг учраас бодит үнэлгээг тодорхой хугацаанд хийх шаардлагатай байдаг. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт болох хүнсний аюулгүй байдлын индексийг тооцох аргачлал, тоон үзүүлэлт боловсруулагдаагүй байна. Энэ нь хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалангийн аж ахуйн нэгж, худалдаа, тээвэр, үйлчилгээний хүрээнд хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах харилцаа, үүрэг, хариуцлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж чадахгүй байна.




1.24. Богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнэх салбарын үзүүлэлт, индекс, онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалгүй байгаа нь тухайн салбарын бодлогын үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг тооцож чадахгүй байх үр дагавартай байна.

ҮСХ-оос Улсын хэмжээний жилийн статистик тоон мэдээллийг харилцан адилгүй хугацааны давтамжтай тархааж байгаа нь бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг зөв тооцох боломжгүй байна

1.25. ХБТТУТ-д богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, УИХ-аар батлуулах, бодлогын хэрэгжилт, үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж эрх бүхий байгууллагад хүргүүлэх, УИХ-аар хэлэлцүүлэх эрхтэй дараах байгууллага байна.

Дүрслэл 2. УХЖТ-г боловсруулж, батлуулах хугацаа

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах хугацаа




Эх сурвалж: ХБТТУТХ, ТХШТХ

1.26. Мөн аудитын баг ХБТТУТХ болон МУИХХШТХ-ийн хүрээнд богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын эрх бүхий байгууллага болон УАГ-ын хуулийн хугацааны цаглаврыг авч үзлээ.

Дүрслэл 3. УХЖТ-ний хэрэгжилт үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах хугацаа

УХЖТ-ний хэрэгжилт үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах хугацаа



Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд хийсэн аудитын багийн дүн шинжилгээ

1.27. Дээрх байдлаас харахад ТЗТБ-аас бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг 01 дүгээр сарын 01-нд ЭЗХЯ-д ирүүлдэг бөгөөд ЭЗХЯ болон ЗГХХГ нь тус бүр 15 хоногт багтаан үнэлгээ дүгнэлтийг гаргадаг байна.

1.28. Улсын хэмжээний албан ёсны тоо мэдээллийн тархаалтын хугацаа харилцан адилгүй давтамжтай байгаа нь ХБТТУТХ болон МУИХХШТХ-д заасан цаглаварт хугацаанд тухайн мэдээллийг ашиглах боломжгүй, эрх бүхий байгууллагаас бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой, үнэн зөв тайлагнах нөхцөл үүсэхгүй зэргээс шалтгаалж бодлогын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг бодитой үнэлж дүгнэх боломжгүй байна.

1.29. ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.7.1, 9.7.2 дахь заалтын дагуу ҮСХ-оос статистик мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)-аар дамжуулан 7 хоног, 15 хоног, сар, улирал, жилийн албан ёсны тоон мэдээ, өгөгдөл, эмхэтгэл, танилцуулгыг нээлттэйгээр ашиглах боломжтойгоор тархааж байгаа ч уг хуульд чиг үүргийг хэрэгжүүлэх хугацааг зааж өгөөгүй байна.

1.30. Харин ҮСХ-ны даргын 2023.12.28-ны өдрийн А/179 дугаар тушаалаар баталсан "Албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны үр дүнг тархаах 2024 оны хуваарьт ...улсын хэмжээний нэгдсэн тоо, мэдээллийг дараа оны 2 сараас 8 сарын хооронд тархааж байхаар тусгасан байна. Тус хороонд эрх бүхий байгууллагаас тоон мэдээг ирүүлдэг хугацаа, мэдээлэл боловсруулалтад шаардагдах хугацаа, мэдээлэл тархаалтын хугацаа харилцан адилгүй хугацааны давтамжтай байгаа нь тухайн

ҮСХ

9.7.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.7.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах;

тодорхой хугацаагүй

мэдээллийг ашиглахад цаг үетэйгээ нийцэхгүй байх үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал:

- Монгол Улсын Статистикийн эмхэтгэл-2023"-ыг 2024.06.30-ны өдөр тархаана,
- Монгол Улсын Нийгэм, эдийн засгийн байдал"-ын 2024 оны 1-11 сарын дүнг /2024 оны жилийн эцсийн дүнг тараах нь батлагдаагүй/... 2024 оны 12 сард тархаана,
- Үндэсний тооцоо: ДНБ, ҮО-ийн жилийн дүнг 2024 оны 8 сарын 17-нд тархаана... гэж тусгасан нь Эдийн засаг, нийгмийн салбарын сар, улирлын мэдээ гарсны дараа тухайн салбарын мэдээнд үндэслэн / мэдээ гаргагч байгууллагаас жилийн дүнг 4 сарын 10-30 хооронд ирүүлж, тус хорооноос 30-70 хоног мэдээллийг боловсруулж, жилийн дүнг 8 сарын 17-нд тархаах/ улирал, жилийн мэдээллийг тархааж байна.

1.31. Улсын хэмжээний эдийн засаг, бизнес, нийгэм, хүний хөгжлийн үзүүлэлт бүхий статистик мэдээлэл тархаалтын хугацаа харилцан адилгүй хугацааны давтамжтай байгаагаас шалтгаалж богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн үнэн зөв тайлагнагдахгүй, эрх бүхий байгууллагаас хэрэгжилт үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийхгүй байх, бодлогын үр нөлөө бодитоор үнэлэгдэх, үнэлэх боломжгүй нөхцөл бүрдэж байна.


БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЗАРИМ ТООН МЭДЭЭЛЭЛ, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ГАРГАХ ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА БОЛООГҮЙГЭЭС 3 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙД ХҮРЧ 5 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 68.8 ХУВЬТАЙ БАЙНА

НЭГ. ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Гадаад худалдааны бараа эргэлтээр 2024 онд экспортын хэмжээ 15.8 тэрбум.ам долларт хүрч өмнөх оноос 0.6 тэрбум.ам доллароор нэмэгдсэн ч, ТАХ-ний дундаж үнэлгээ 40 хувьтай буюу зорилт үр дүнг бүрэн хангагдаагүй байна

Дүрслэл 4. Экспортын хэмжээ

2.1. Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлтээр экспортын хэмжээ 2024 онд 15.8 тэрбум.ам.долларт хүрснээс эрдсийн бүтээгдэхүүн 13.8 тэрбум.ам доллар буюу 87.2 хувь, бусад бүтээгдэхүүн 2.0 тэрбум.ам.доллар буюу 12.7 хувийг эзэлж, экспортын нийт хэмжээ өмнөх оноос 0.6 тэрбум.ам доллароор нэмэгдсэн байна.



Эх сурвалж:ҮСХ-ны 1212.мн

2.2. Мөн “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 1.4.1.”Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна” хөтөлбөрийн үр дүнгээр 2024 онд экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацаа 31 цаг 54 минут болсон нь зорилтот үр дүнг 2 дахин багасгасан эерэг үзүүлэлттэй байна.

2.3. “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 4 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 4 ТЕЗ-ийн үр дүн 84 хувь, 7 хөтөлбөрийн үр дүн 68 хувийн биелэлттэй зорилтот үр дүнг хангасан байна.

Хүснэгт 8. Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл

№	Үзүүлэлт	Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээ ний дундаж /хувь/	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	3		1		4	84.0	ЗТЯ-1,ХХАХҮЯ-1, Сангийн яам-2
2	Хөтөлбөрийн үр дүн	3	1	2	1	7	68.0	ЗТЯ-3, ХХААХҮЯ-2, ЭЗХЯ-1,Сангийн яам-1
Нийт дүн		6	1	3	1	11		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.4. Харин “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 7 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 23 ТАХ-ээс 6 ТАХ тодорхой үр дүнд хүрч, 17 ТАХ-ээс үр дүнгүй 10, эрчимжүүлэх шаардлагатай 7 арга хэмжээ буюу ТАХ-ний дундаж үнэлгээ 40 хувьтай буюу зорилтот үр дүн бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 9 Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл


№	Үзүүлэлт	Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж /хувь/	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		

1	Төсөл, арга хэмжээ	1	5	7	10	23	40.0	ЗТЯ-11, ХХААХҮЯ-4, ЭЗХЯ-1, Сангийн яам-3, ХХЗХЯ-1, НЗДТГ-1, Шадар сайд /ГХХОА/-1
---	--------------------	---	---	---	----	----	------	--

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

Дүрслэл 5. Ачаа эргэлт

2.5. Тухайлбал: 1.1.“Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ” гэсэн ТАХ нь ТЕЗ-ийн үр дүнгээр 2024 онд ачаа эргэлт 33,992.7 сая.тонн/км-т хүргэж зорилтот үр дүнг хангаж, үүнээс 12,746.1 сая.тн/км авто тээвэрээр, 21,217.6 сая.тн/км төмөр замаар, 29.0 сая.тн/км агаарын тээвэрээр ачаа эргэлт хийсэн байна.



Эх сурвалж: YCX-ны 1212.mn

2.6. “Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ” гэсэн ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 1.1.1. “Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ”, 1.1.2. “Авто замын сүлжээг өргөтгөнө” хөтөлбөрийн хэрэгжилт нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

2.7. Харин “Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах ч 10 ТАХ-ний хэрэгжилт нь ТЭЗҮ батлагдаагүй, гэрээ хэлэлцээр удааширсан, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалт хангалтгүй, ТХААГ-аас концессоор зарлагдсан төслүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 онд явуулаагүй зэрэг шалтгаанаас тухайн арга хэмжээний хэрэгжилт нь зорилтот үр дүнд хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай 4 ТАХ, үр дүнгүй 6 ТАХ байна. Тухайлбал:

1.1.1. “Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ” хөтөлбөрт хамаарах:

- 1.1.1.2. “Ханги-Мандал боомтын хил дамнан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” ЗГ хоорондын хэлэлцээрт нэмж тусгах талаар Хятадын талтай хэлэлцээ удааширсан нь “төмөр замын урт 10 км хүргэх” зорилтот үр дүнд хүрээгүй./ЗТЯ. 50 хувь,эрчимжүүлэх шаардлагатай/
- 1.1.1.4. “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих” арга хэмжээний Зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаатай холбоо хангалтгүйгээс /төмөр замын төсөлд бүрэн шинжилгээ хийх “Төслийн баг байгуулах тухай” ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024.10.30-ны өдрийн А/264 дугаар тушаал гарч, ТХХТТөв бүрэн шинжилгээг хийх явцад материал дутуу хүргүүлсэн/ барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүргэх зорилтот үр дүнг хангаагүй байна. /ЗТЯ. 50 хувь,эрчимжүүлэх шаардлагатай/
- 1.1.1.5. “Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих” арга хэмжээний ТЭЗҮ батлагдаагүйгээс барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй./ ЗТЯ,10 хувь, үр дүнгүй/

1.1.2. “Авто замын сүлжээг өргөтгөнө” хөтөлбөрт хамаарах:

- 1.1.2.2. “Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих”⁹ ажлын явцад орон нутгийн малчдын эсэргүүцэлтэй тулгарч гэрээний хугацаанд

9 Засгийн газрыг төлөөлж ҮХГазар, “Ундрах говь” ХХК-ийн хооронд 2018.12.04-ны өдөр Концессын гэрээг зураг төсөл боловсруулах, барих-ашиглах шилжүүлэх (DBOT) нөхцөлтэй гэрээг анх байгуулж уг Концессын гэрээнд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 2021.11.25-ны өдөр ТХААГ-тай, 2024.12.09-ны өдөр гэрээнд өөрчлөлт оруулах тухай гэрээг ЭЗХЯ-тай байгуулсан байна. ЗТХЯ-аас 2022.01.28-ны өдрийн 06/01/2022 дугаар Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгож, 2024.03.29-ний өдөр зөвшөөрлийн хугацаанд /2026.05.31-ны өдөр хүртэл/ сунгалт хийсэн байна.

барилгын ажил хийгдээгүй¹⁰ нь барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх зорилтот үр дүн хангаагдаагүй байна. /ЗТЯ. 29 хувь, үр дүнгүй/.

- 1.1.2.5. “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барих” болон 1.1.2.6. “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Улиастай-Алтай чиглэлийн 42 км авто зам барих” арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа болон гэрээний явц удааширснаас барилгын ажлын гүйцэтгэл 15 хувьд хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй байна. /ЗТЯ. 0-10 хувь, үр дүнгүй/
- 1.1.2.4. “Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” арга хэмжээний ТХААГ-аас концессоор зарлагдсан төслүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 онд явуулаагүй¹¹ нь барилгын ажлын гүйцэтгэлийг 20 хувьд хүргэх зорилтот үр дүн хангаагдаагүй байна. /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/.

2.8. 1.2.“Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ” ТЭЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 2024 онд экспорт 95.31 сая.тонн, импорт 7.82 сая.тонн ба нийт цэвэр жин нь 103.14 сая.тонн-д хүрч зорилтот үр дүнг хангасан ч дараах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг оновчгүй тодорхойлсноор зорилтот үр дүнг хангаагүй байна. Үүнд:

- 1.2.1.5. “Цагаандэл-Уул хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх” арга хэмжээний боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтыг 100 хувьд хүргэх зорилтот түвшинг баталсан нь оновчгүй бөгөөд ажлын ТЭЗҮ, зураг төслийн ажил дуусаагүй нь зорилтот үр дүнг хангахгүй байх нөхцөл болжээ./ Боомтын сэргэлтийн Үндэсний хороо,10 хувь, үр дүнгүй/

2.9. 1.3. “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” ТЭЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 2024 оны жилийн эцэст экспорт 423.8 сая долларт хүрч зорилтот үр дүнг 82.8 сая.ам.доллараар хангаагүй, ТЭЗ-ийн үр дүнд хамаарах дараах хөтөлбөр, арга хэмжээ нь зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа хангалтгүйгээс зорилтот үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- 1.3.1.“Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг бий болгоно” хөтөлбөрийн хүрээнд “Шинэ ховд дэд бүтэц” ажлын гүйцэтгэл 58 хувь, “Дархан арьс шир дэд бүтэц” ажлын болон 1.3.1.2. “Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар тухайн онд санхүүжүүлэх дүнг 59.2 тэрбум төгрөгөөр баталсан ч төсвийн тодотголоор хасагдсан, Засгийн газрын 2024.4.24-ны өдрийн хуралдаанаар тус ажлыг хойшлуулах..., 2024.12.30-ны өдрийн 256 дугаар тушаалаар Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-ийн нэрийг “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК гэж өөрчлөн үйл ажиллагааг явуулах шийдвэр гарч, уг ажил ТЭЗҮ боловсруулах шатанд байгаа нь зорилтот үр дүн хангаагдахгүй байх нөхцөл болсон байна. /ХХААХҮЯ, 20 хувь, үр дүнгүй/.
- 1.3.2. “Олон улсын худалдаанд хорио саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулна” хөтөлбөрийн 1.3.2.2. “Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулах” ТАХ-ний хүрээнд Дорноговь аймагт ямааны годрон өвчин гарсны улмаас ДМАЭМБ-д тайлан илгээгдээгүй байна. /ХХААХҮЯ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/.

2.10. “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнд хамаарах эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй үнэлэгдсэн ТАХ нь ТЭЗҮ батлагдаагүй, гэрээ хэлэлцээр удааширсан, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалт хангалтгүй, ТХААГ-аас концессоор зарлагдсан төслүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 онд явуулаагүй зэргээс шалтгаалсан байна.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2024 онд 4 тэрбум ам.долларт хүрч зорилтот түвшинг хангасан байна. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх


10 2024 онд Хүрмэн сумын нөлөөллийн бүсэд байгаа 63 өрхөд нөхөн олговор олгосон байна. Өмнөговь аймгийн Хүрмэн сум, Ханхонгор сум, Номгон сумын Засаг дарга нараас 2024 оны 5 сараас 7 сарын хооронд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг концесс эзэмшигч Ундрах Говь ХХК-д ирүүлсэн

11 Концессын тухай хууль 2023.12.31-ний өдрөөс хүчингүй болсноор

чиглэлд хамаарах ТАХ-ний дундаж үнэлгээ 51.2 хувьтай буюу зорилтот үр дүнг бүрэн хангаагүй байна

Дүрслэл 6 Гадаадын шууд хөрөнгө оруулалт /тэрбум.ам.доллар/

2.11. 2024 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 4 тэрбум ам.доллар, буцаалт болон зээлийн эргэн төлөлт 1.5 тэрбум ам.доллар байсан ба цэвэр дүн 2.5 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Үүнд: 1-р улиралд 0.9 тэрбум ам.доллар, 2-р улиралд 1.2 тэрбум ам.доллар, 3-р улиралд 0.8 тэрбум ам.доллар, 4-р улиралд 1.1 тэрбум ам.доллар байна.



Эх сурвалж. Монголбанкны статистик мэдээ

2.12. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 5 ТЕЗ-ийн үр дүн 42 хувь, 11 хөтөлбөрийн үр дүн 42.9 хувьтай буюу зорилтот үр дүн бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 10 “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн /тоо, хувиар/

№	Үзүүлэлт	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээ ний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	-	1	3	1	5	42.0	ШСАА /ОБАЭ/-1, ЭЗХЯ-1, АҮЭБЯ-1, ССАЖЗЯ-1, ЭХЯ-1
2	Хөтөлбөрийн үр дүн	1	3	2	5	11	42.9	Монголбанк-1, ШСАА /ОБАЭ/-1, ССАЖЗЯ-2, АҮЭБЯ-3, ЭЗХЯ-2, ЭХЯ-2
Нийт дүн		1	4	5	6	16		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.13. Харин “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 12 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилт үр дүнтэй 9, тодорхой үр дүн хүрсэн 10, эрчимжүүлэх шаардлагатай 15, үр дүнгүй хэрэгжсэн 18 буюу нийт 52 ТАХ-ний дундаж үнэлгээ 51.2 хувьтай буюу зорилтот үр дүн бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 11. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн ТАХ-ний үр дүн /тоо, хувиар/

№	Үзүүлэлт	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	Төсөл, арга хэмжээ	9	10	15	18	52	51.2	ЗГХЭГ-1, ШСАА /ГХХОАХ/-1, ШСАА /ОБАЭ/-2, Монголбанк-1, НЗДТГ-1, СЗХ-1, ЭЗХЯ-5, БХБЯ-1, Боловсролын яам-1, ССАЖЗЯ-7, АҮЭБЯ-14, ЭХЯ-17

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.14. 2.1 “Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн “Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг 7-оор нэмэгдүүлнэ” шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнээс БНСУ-тай 4 шатны хэлэлцээр хийгдсэн, бусад 3 улстай хийх хэлэлцээр эхлэлийн шатанд байна.

2.15. Тус ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 2.1.1. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлнэ, 2.1.2. Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн бол 2.1.3. “Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ” хөтөлбөрийн хэрэгжилт эрчимжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- 2.1.1.2. “Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гаргасан гомдлыг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх” арга хэмжээний ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг 100 хувьд хүргэнэ гэсэн шалгуур үзүүлэлт биелэгдээгүй байна. /ЭЗХЯ. 36 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 2.1.1.3. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвөөр дамжуулан түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн бэлэн байдлыг хангуулах” гэсэн ТАХ нь Зохион байгуулалттай холбоотойгоор бүрэн хэрэгжээгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай байна. /ЭЗХЯ, 35 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

2.16. 2.2 “Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн “Уул уурхайн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин” шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хариуцагч байгууллага хамааралгүй мэдээллийг тайлагнасан ба нотлох баримтаар дэмжигдээгүй тул үр дүнгүй үнэлэгдсэн байна. Мөн 2.2.1. “Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ”, 2.2.2. “Зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ”, 2.2.3. “Боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй байна. Тухайлбал:

- 2.2.1. “Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн “нийт нутаг дэвсгэрт хайгуул хийсэн талбайн эзлэх хувийг 60-д хүргэнэ” шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болон зорилтот түвшинг үндэслэлгүй баталсан нь зорилтот түвшинг хангахгүй байх нөхцөлийг бий болгосон байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон талбай 3.4 хувь байгаа нь тус зорилтыг хангах боломжгүй болсон. /АҮЭБЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 2.2.3. “Боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрээнд хүрсэн түвшинг 54.8 гэж тайлагнасан нь суурь түвшинээс буурсан мөн нотлох баримтаар дэмжигдээгүй. /АҮЭБЯ. хувь, үр дүнгүй/

Дүрслэл 7 Эрчим хүчний түгээлтэд эзлэх хувь

2.17. 2.3 “Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 2024 онд улсын хэмжээний цахилгааны нийт түгээлт 10,589,916 мян.кВт.цаг байгаа ба үүнд дотоодын эх үүсвэрээс 7,750,196.8 мян.кВт.цаг түгээлт хийж, цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь 73.1%-ийг эзэлж байгаа нь зорилтот түвшинд бүрэн хүрээгүй байна.



Эх сурвалж: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ

2.18. Тус ТЕЗ-ийн үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлсэн 2 хөтөлбөр үр дүнгүй, нийт 18 төсөл, арга хэмжээнээс 8 ТАХ үр дүнтэй, тодорхой үр дүнд хүрч 10 ТАХ үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- 2.3.1. “Эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно” хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний компаниудыг санхүүгийн алдагдалгүй болгоно гэж зорилтот түвшинг тодорхойлсон хэдий ч 2024 оны хагас жилийн байдлаар 76 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. /ЭХЯ, 29 хувь, үр дүнгүй/

- 2.3.2. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрээнд нэг хэрэглэгчид ногдох цахилгааны тасалдлын үргэлжлэх дундаж хугацааг 9 цагт хүргэнэ гэсэн 16 цаг байгаа тул үр дүнгүй. /ЭХЯ, 29 хувь, үр дүнгүй/
- 2.3.2.1. “Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” ТАХ нь төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотойгоор тендерт оролцогчдын зүгээс шүүхэд гомдол гаргаж төсөл зогсонги байдалд орсон байна. /ЭХЯ, 0 хувь, үр дүнгүй/
- 2.3.2.4. Амгалангийн дулааны станцыг өргөтгөх /ЭХЯ. 95%, тодорхой үр дүнд хүрсэн/
- 2.3.2.6. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх /ЭХЯ. 100 хувь, үр дүнтэй/
- 2.3.2.9. 10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх /ЭХЯ. 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 2.3.2.10. 220/110/35 кВ-ын Багануур дэд станцыг 220 кВ-аар өргөтгөж, шинэчлэх /ЭХЯ. 100 хувь, үр дүнтэй/
- 2.3.2.11. “Эрдэнэбүрэн-Мянгадын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” ТАХ нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих байсан ч төслийн ажил зогссон байна. /ЭХЯ, 0 хувь, үр дүнгүй/

2.19. 2.4 “Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна” ТЕЗ-ийн үр дүнгийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг гаргахдаа зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалд “урлаг, үзвэр, тоглоом, наадам” үзүүлэлтийг хамруулан гаргаж 0.4 хувьтай тодорхойлсон байгаа нь зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаатай холбоотойгоор зорилтот түвшинд хүрээгүй буюу үр дүнгүй байна. Мөн тус ТЕЗ-ийн үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлсэн 2 хөтөлбөр, 7 ТАХ-ээс 1 хөтөлбөр, 3 ТАХ үр дүнтэй хэрэгжсэн ч 1 хөтөлбөр, 4 ТАХ үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдсэн байна. Тухайлбал:

- 2.4.1. “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлнэ гэж төлөвлөсөн хэдий ч суурь түвшин өөрчлөгдөөгүй, мөн тухайн шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь хэмжих боломжийг бүрдүүлээгүй байна. /ССАЖЗЯ, 40 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 2.4.1.2. “Монгол кино үйлдвэрийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төв болгох” төслийн хүрээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын Олон талт арга хэмжээний ажлын зураг төсөл, төсөв нь 23,465.79 сая төгрөгөөр хянан баталгаажсан бөгөөд барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдсан. /ССАЖЗЯ, 29 хувь, үр дүнгүй/
- 2.4.2.1. “Байгалийн түүхийн музей /хуучнаар Лениний музей/-г шинэчлэн засварлах” ТАХ-ний Магадлалын ерөнхий дүгнэлт гарсан бөгөөд санхүүжилт шийдэгдээгүй тул засварын ажил эхлээгүй байна. /ССАЖЗЯ, 29 хувь, үр дүнгүй/
- 2.4.2.2. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ССАЖЗЯ, 100 хувь, үр дүнтэй/
- 2.4.2.2. Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори байгуулах /ССАЖЗЯ, 100 хувь, үр дүнтэй/
- 2.4.2.4. Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийг хийж гүйцэтгэх /ССАЖЗЯ, 100 хувь, үр дүнтэй/

2.20. 2.5 “Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна” ТЕЗ-ийн үр дүнгийн хүрээнд 3 чөлөөт бүсийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлыг эхлүүлж тодорхой үр дүнд хүрсэн ч тухайн ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт шийдэгдээгүй тул эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- 2.5.1.1. Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг үргэлжлүүлэх /Сэлэнгэ, Алтанбулаг/ /ШСАА /ОБАЭ/, 65 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 2.5.1.2. Алтанбулаг чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох /ШСАА /ОБАЭ/, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

2.21. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнд хамаарах эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй үнэлэгдсэн ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, ТАХ нь санхүүжилт бүрэн шийдэгдээгүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалтаас шалтгаалсан байна.

ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас улс орнуудын Хүний хөгжлийн индексийн тайланг 4 жилд нэг удаа гаргадаг тул тэргүүлэх чиглэлийн үр дүнг 2024 оны байдлаар үнэлэх боломжгүй байна

2.22. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт “Хүний хөгжлийн үзүүлэлт”-ийг НҮБ-аас 4 жилд нэг удаа гаргадаг байна. Тус тайлан, илтгэлийн тодорхой үзүүлэлтүүдийг тоон утгаар илэрхийлэх бөгөөд манай улсын үзүүлэлт өсөлттэй гарч байгаа ч Монгол Улс 2019 онд 99, 2023 онд 96 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Иймд тэргүүлэх чиглэлийн хүрсэн түвшинг улс орнуудын эрэмбээр хэмжих боломжгүй байна.

2.23. Үндэсний статистикийн хорооноос Хүний хөгжлийн индексийг тооцох аргачлалыг 2014 батлан, тус аргачлалын дагуу 2019 онд 0.737, 2020 онд 0.775, 2021 онд 0.776, 2022 онд 0.781, 2023 онд 0.788 үзүүлэлттэй гарсан байна. 2024 оны үзүүлэлт гараагүй байна.

2.24. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд 8 шалгуур үзүүлэлт бүхий 3 ТЕЗ-ийн үр дүн, 15 шалгуур үзүүлэлт бүхий 11 хөтөлбөрийн үр дүн хамаарч байна.

Хүснэгт 12. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл

/тоо, хувиар/

№	Үзүүлэлт	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж /хувиар/	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	1	1	1	-	3	76.7	БЯ-1, ГБХНХЯ-1, ЭМЯ-1
2	Хөтөлбөрийн үр дүн	1	3	4	3	11	51.2	БЯ-3, ЭЗХЯ-2, ГБХНХЯ-2, ЭМЯ-2, ССАЖЗЯ-1, ТА3-1
Нийт		2	4	5	3	14		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.25. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 37 шалгуур үзүүлэлт бүхий 28 ТАХ хамаарч байна.

Хүснэгт 13 “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл

/тоо, хувиар/

№	Үзүүлэлт	“Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж /хувиар/	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	Төсөл, арга хэмжээ	9	11	3	5	28	71.6	БЯ-11, ССАЖЗЯ-3, ГБХНХЯ-4, ЭЗХЯ-1, ЭМЯ-9

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.26. “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тусгасан бөгөөд “Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувийг 61.2 хувьд хүргэнэ”, “Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь /их, дээд сургууль/-ийг 71.9 хувьд хүргэнэ” шалгуур үзүүлэлтүүд хүрэх түвшинд хүрч, үр дүнтэй хэрэгжсэн, “Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 75.8 хувьд хүргэнэ” шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 69.5 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна. Харин “Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж хувийг 41.6 хувьд хүргэнэ”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж хувийг 49.8 хувьд хүргэнэ”

гэсэн 2 шалгуур үзүүлэлт нь *Боловсролын чанарын үнэлгээний шалгалтыг 3 жилд 1 удаа зохион байгуулдаг ба 2025 онд уг шалгалтыг зохион байгуулах тул үнэлэх боломжгүй* байна.

2.27. “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 5 хөтөлбөрийн 8 шалгуур үзүүлэлтийн үр дүнг үнэлэхэд тодорхой үр дүнд хүрсэн 2, эрчимжүүлэх шаардлагатай 3, үр дүнгүй 2 шалгуур үзүүлэлт байна. Тухайлбал:

3.1 “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах:

- 3.1.2. “Дээд боловсролын судалгааг эдийн засгийн эргэлтэд оруулна” хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Гадаадад хэвлүүлсэн импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийг 906-д хүргэнэ гэж тусгасан ч 499 өгүүллийг хэвлүүлсэн байна. /ЭЗХЯ, 50 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 3.1.3. “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна” хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Шинэ зохиогчийн эрхийн гэрчилгээ 1000 олгохоор тусгаснаас 875 гэрчилгээ олгосон байна. /ЭЗХЯ, 87.5 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 3.1.4. “Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн эзлэх хувийг 76 хувьд хүргэхээр тусгасан ч нийт ЕБС-ийн 72.8 хувь нь дотоод болон гадаад орчны стандартыг хангасан байна. /Боловсролын яам, 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

2.28. “Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 12 ТАХ-ний 20 шалгуур үзүүлэлтээс үр дүнтэй 5, тодорхой үр дүнд хүрсэн 10, шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинг оновчтой тогтоогоогүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалттай холбоотойгоор эрчимжүүлэх шаардлагатай 3, үр дүнгүй 2 ТАХ байна. Тухайлбал:

3.1.1. “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийн тоог нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 3.1.1.1. “Бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн КООСЭН сургалтын хөтөлбөрийг аймаг бүрд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “КООСЭН сургалтын хөтөлбөр нэвтрүүлсэн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын тоог 24-т хүргэхээс 6 байгууллагад хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна. /Боловсролын яам, 29 хувь, үр дүнгүй/

3.1.2. “Дээд боловсролын судалгааг эдийн засгийн эргэлтэд оруулна” хөтөлбөрт хамаарах:

- 3.1.2.1. “Их, дээд сургуулиудын магистр, докторын судалгааны сэдвийг төрийн болон хувийн хэвшилд хэрэгцээтэй байгаа судалгаатай уялдуулах тогтолцоог нэвтрүүлэх” арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувьд хүргэхээр тусгасан ч хэрэгжилт эхлэлийн шатанд байна. /Боловсролын яам, 29 хувь, үр дүнгүй/

3.1.4. “Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 3.1.4.1. “Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих” ажлын хүрээнд 49 сургуулийг ашиглалтад оруулахаар төлөвлөж 36 сургуулийг ашиглалтад оруулсан байна. /Боловсролын яам, 73 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 3.1.4.3. “Дотуур байр барих” ажлын хүрээнд 10 дотуур байр барихаар төлөвлөж 10-ыг ашиглалтад оруулж зорилтот түвшинг хангасан байна. /Боловсролын яам, 100 хувь, үр дүнтэй/
- 3.1.4.5. “Сургуулийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх” ажлын хүрээнд 346 сургууль, цэцэрлэг, дотуур байрыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангахаар төлөвлөж 208 АЦБ-ийг стандартын шаардлага хангуулсан байна. /Боловсролын яам, 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 3.1.4.6. “Үдийн хоол үйлдвэрлэлийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах” ажлын хүрээнд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлага хангасан сургуулийн эзлэх хувийг 70 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч 885 сургуулиас 460 сургуулийн хоолны

газар /65.5 хувь/ стандартын шаардлагад нийцсэн байна. /Боловсролын яам, 77.5 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

2.29. 3.1.5.1. “Цэцэрлэгийн барилга барих” ТАХ-нд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 3 цэцэрлэг барихаар төлөвлөсөн ч УБ хотод 1 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 1 цэцэрлэг таван хувийн гүйцэтгэлтэй, орон нутагт 2 цэцэрлэгийн барилга 50 хувийн гүйцэтгэлтэй байна. /Боловсролын яам, 65 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

2.30. “Нийгмийн баталгааг сайжруулна” ТЕЗ-ийн хүрэх түвшинг Төсвийн санхүүжүүлэх зардлын ДНБ-д эзлэх хувийг 3.3 хувиас бага байхаар төлөвлөж 2024 онд НДС-ийн улсын төсвийн санхүүжилт-1175.0 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ний 1.5 хувийг эзэлж зорилтот түвшинг хангасан байна.

2.31. Тус ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 3 Хөтөлбөрийн үр дүнгээс тодорхой үр дүнд хүрсэн 2, эрчимжүүлэх шаардлагатай 1 хөтөлбөр байна. Тухайлбал:

- 3.2.1. “Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ” хөтөлбөрийн үр дүнг Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцааг 33 хувь байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр дундаж харьцаа 29.4 хувь байна. /ГБХНХЯ, 89.1 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 3.2.2. “Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлнэ” хөтөлбөрийн хүрэх түвшинг Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцааг 0.9 хувьд хадгалахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 0.84 хувь байна. /ГБХНХЯ, 89.1 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

2.32. “Өвчлөл, нас баралтыг бууруулна” ТЕЗ-ийн үр дүнг 2 шалгуур үзүүлэлтээр тооцохоор тусгасан бөгөөд “Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/-г Продецимил /10,000 хүнд, нэгжид ногдох үзүүлэлт/ үзүүлэлтийг 26-д хүргэж бууруулахаар төлөвлөсөн ч 2024 онд тус үзүүлэлт 38.4 болж өссөн тул хэрэгжилт үр дүнгүй /0/, харин 10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоог Продецимил үзүүлэлтээр 779.1 болгож бууруулахаар төлөвлөж, хэрэгжилт 95.1 болж буурсан тул үр дүнтэй хэрэгжсэн /100/ байна.

2.33. “Өвчлөл, нас баралтыг бууруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 3 хөтөлбөрийн үр дүнгээс үр дүнтэй 1, үр дүнгүй 1, үнэлэх боломжгүй 1 хөтөлбөр байна. Үүнд:

- 3.3.1. “Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ” хөтөлбөрийн үр дүнг Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасан эмийн эзлэх хувийг 18.7 хувьд хүргэхээр төлөвлөж зорилтот түвшинд хүрсэн байна. /ЭМЯ, 100 хувь, үр дүнтэй/
- 3.3.2. “Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрэх түвшинг Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтыг 67.5 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч тус үзүүлэлтийг 2021 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тооцож гаргаснаас хойш мэдээллийг шинэчлээгүй тул үнэлэх боломжгүй байна. /ЭМЯ, үнэлэх боломжгүй/
- 3.3.3. “Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрэх түвшинг Хөдөлгөөний хомсдолтой 15-69 насны хүн амын эзлэх хувийг 17.5 хувьд хүргэж бууруулахаар төлөвлөсөн ч тус үзүүлэлт 2024 оны байдлаар 29 хувьтай байна. /ЭМЯ, 0 хувь, үр дүнгүй/

2.34. “Өвчлөл, нас баралтыг бууруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 13 шалгуур үзүүлэлт бүхий 12 ТАХ-ний хэрэгжилт үр дүнтэй хэрэгжсэн 5, тодорхой үр дүнд хүрсэн 3, эрчимжүүлэх шаардлагатай 2, үр дүнгүй 3 арга хэмжээ байна. Тухайлбал:

- 3.3.2.6. “Бүх шатны эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэх /өвчний түүх, эмчилгээний түүх, эмчийн онош, жор/” ТАХ-ний хэрэгжилтийг нийт эмийн сангийн 10 хувийг холбохоор төлөвлөж гүйцэтгэлээр 73.5 хувийг холбож үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. /ЭМЯ, 100 хувь, үр дүнтэй/
- 3.3.2.5. Эмчилгээний хамгийн сүүлийн үеийн зааварчилгаа, туршлага хуваалцах платформд бүрэн холбогдох /up to date/ ТАХ-ний хүрэх түвшинг “Хэрэглээнд нэвтэрсэн зааварчилгаа”-г 50-д хүргэхээр төлөвлөж 45 зааварчилгаа гаргасан байна. /ЭМЯ, 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 3.3.2.1. “Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх” арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч 2024 онд Гадна инженерийн шугам, сүлжээний ажил, газар шорооны ажил, барилга

байгууламжийн каркас угсралтын ажил хийгдсэн байна. /ЭМЯ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

2.35. 3.3.2.4. “Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих” барилгын ажлыг 2024 онд бүрэн барьж дуусгахаар төлөвлөсөн байна. Худалдан авах ажиллагааг зарласан ч оролцогч санал ирүүлээгүй тул хэрэгжээгүй байна. /ЭМЯ, 0 хувь, үр дүнгүй/

2.36. “Нийгмийн баталгааг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 4 шалгуур үзүүлэлт бүхий 4 ТАХ-ний хэрэгжилт үр дүнтэй хэрэгжсэн 3, тодорхой үр дүнд хүрсэн 1 арга хэмжээ байна. Тухайлбал:

- 3.2.1.2. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх” ТАХ-ний хэрэгжилтийг нэмэгдсэн хувиар тооцохоор төлөвлөж гүйцэтгэлээр 2024 онд Инфляцийн түвшин 9 хувьтай гарч бүрэн тэтгэвэр 18.2 хувиар, хувь тэнцүүлсэн 22.7 хувиар өссөн. /ГБХНХЯ, 100 хувь, үр дүнтэй/
- 3.2.3.1. “Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх” ТАХ-ний хэрэгжилтийг нэмэгдсэн хувиар тооцохоор төлөвлөж гүйцэтгэлээр төрийн албан хаагчийн цалин 10-11 хувиар өссөн дүнтэй байна. /ГБХНХЯ, 100 хувь, үр дүнтэй/

2.37. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн “Хүний хөгжлийн үзүүлэлт” шалгуур үзүүлэлтийг улс орнуудад эзлэх эрэмбээр хэмжихээр төлөвлөж уг үзүүлэлт нь НҮБ-ын Хүний хөгжлийн тайлангийн цаглавар болоогүй, Үнэлэх боломжгүй 1 ТЕЗ-ийн үр дүнгийн 2 шалгуур үзүүлэлт болох “Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж” үзүүлэлтүүдийг олон улсын жишгээр 3 жилд 1 удаа гаргадаг, хугацаа болоогүй шалтгаанаар тус тус үнэлэх боломжгүй байна.

ДӨРӨВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

“Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтээр 2024 онд Монгол улсын хүлээн авах гадаад жуулчны тоог 1,3 саяд хүргэхээр төлөвлөсөн ч 0,7 сая жуулчин хүлээн авснаар зорилтот түвшинг хангаагүй байна

2.38. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 2 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 3 ТЕЗ-ийн үр дүн 58 хувь, 3 хөтөлбөрийн үр дүн 17 хувиар үнэлэгдэж зорилтын үр дүнг хангаагүй байна.

Хүснэгт 14. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгтгэл /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	1	1		1	3	58.0	ССАЖЗЯ-1, ЗТЯ-2
2	Хөтөлбөрийн үр дүн			1	2	3	17.0	ССАЖЗЯ-1, ЗТЯ-2
	Нийт дүн	1	1	1	3	6		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.39. Харин “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 3 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 35 ТАХ-ээс 7 ТАХ тодорхой үр дүнд хүрч, 28 ТАХ-ээс үр дүнгүй 21, эрчимжүүлэх шаардлагатай 7 арга хэмжээ буюу ТАХ-ний дундаж үнэлгээ 28 хувьтай буюу зорилтот үр дүн бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 15 “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнтэй	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		

1	Төсөл, арга хэмжээ	4	3	7	21	35	28.0	ССАЖЗЯ-2, ЗТЯ-32, ГХЯ-1
---	--------------------------	---	---	---	----	----	------	-------------------------------

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.40. 4.1 “Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгээр 2024 онд зорилтот түвшинд хүрсэн ч 4.1.1. “Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгээр Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувийг 8 хувьд хүргэхээр төлөвлөсөн зорилтот түвшин 6,8 хувь буюу “үр дүнгүй” үнэлэгдсэн байна. Монгол Улсад оруулж буй аялал жуулчлалын орлогыг тодорхойлох аргачлал байдаггүй бөгөөд Монгол улсад оруулж буй гадаад жуулчны дундаж орлогыг 2000 ам доллароор тооцоолдог байна.

2.41. 4.1.1. “Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнд хамаарах 5 ТАХ-ээс 2 ТАХ “үр дүнтэй”, 3 ТАХ нь ТЭЗҮ, зураг төсөвгүйгээс “эрчимжүүлэх шаардлагатай” болон үр дүнгүй үнэлэгдсэн байна. Тухайлбал:

4.1.1. “Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 4.1.1.3. “Тусгай бүсийг аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах” арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах худалдан авах ажиллагаа удааширсан нь “4 тусгай бүс байгуулах” зорилтот үр дүнд хүрээгүй. /ССАЖЗЯ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.1.1.4. “Палеонтологийн нөөцөд тулгуурлан “Аялал-Судалгаа-Амралт”-ын цогцолбор байгуулах /Дундговь, Цагаан суварга/” арга хэмжээний ТЭЗҮ боловсруулах санхүүжилт шийдэгдээгүйгээс “барилгын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэх” зорилтот үр дүнд хүрээгүй. /ССАЖЗЯ, ЭЗХЯ, Боя. 0 хувь, үр дүнгүй/
- 4.1.1.5. “Улирлын чанартай “Буйр нуур” усан замын боомт байгуулах” арга хэмжээний ТЭЗҮ боловсруулах санхүүжилт шийдэгдээгүй мөн БНХАУ-ын талаас 2025.01.06-ны өдөр Буйр нуурт усан замын боомт байгуулах “шаардлагагүй” гэж үзсэнээ илэрхийлснээр “1 усан замын боомт” байгуулах зорилтот үр дүнд хүрээгүй. /ЗТЯ, ГХЯ. 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

2.42. 4.2. “Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 4 ТАХ болох Ховд, Мөрөн, Өмнөговь, Чойбалсан аймгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, 4С ангиллын болгох төсөл нь ТЭЗҮ боловсруулагдаагүй, ТХХТТХ-ийн шаардлагыг хангаагүйгээс үр дүнгүй үнэлэгдсэн байна. Мөн дээрх ТЕЗ-ийн үр дүнд хамаарах “4.2.1. Нислэгийн тоог нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгээр 2024 онд нийт 23957 нислэг үйлдэгдсэн нь зорилтот үр дүнд хүрээгүй бөгөөд 49,64 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн байна.

2.43. ЗТЯ-ны хариуцан хэрэгжүүлж буй 4.3. “Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүн 73 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн боловч “Аялал жуулчлалын авто замын сүлжээний урт” хөтөлбөрийн үр дүн гараагүй байна.

2.44. 4.3.1. “Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах 25 ТАХ-ээс 4 ТАХ нь “үр дүнтэй” болон “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлэгдсэн ч 21 ТАХ “эрчимжүүлэх шаардлагатай” болон “үр дүнгүй” үнэлэгдсэн байна. Эдгээр ТАХ-г шалтгаанаар нь ангилбал санхүүжилттэй холбоотойгоор 12 ТАХ, ТЭЗҮ батлагдаагүй болон ХАА удааширснаас 6 ТАХ, зохион байгуулалтын ажиллагаатай холбоотойгоор 3 ТАХ зорилтот үр дүнг хангаагүй байна. Тухайлбал:

4.3.1. “Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах: Санхүүжилт шийдэгдээгүй:

- 4.3.1.4. Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн А0502 дугаартай 50 км авто замын их засвар хийх /Хэнтий/ /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.11. Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100-200 км тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах /амрах өртөө/ /ЗТЯ. 10 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.13. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Хараа голын 85 у/м төмөр бетон гүүр барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/

- 4.3.1.15.Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хооронд 27 км хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэлтийг хийх /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.17.Завхан аймгийн Солонготын давааг 11.66 км хатуу хучилттай болгох авто зам барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.20.Балж голд төмөр бетон гүүр барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/

Санхүүжилт дутуу батлагдсан:

- 4.3.1.1.Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам барих /Дорнод, Баян-Уул сум/ /ЗТЯ. 43,6 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.3.1.2.Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто зам барих /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/ /ЗТЯ. 47 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.3.1.7.Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км /ЗТЯ. 12 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.19.Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх 13 км хатуу хучилттай авто зам барих /ЗТЯ. 29 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.21.Баруун-Урт- Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/ /ЗТЯ. 33,7 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.3.1.25.Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км /ЗТЯ. 15,5 хувь, үр дүнгүй/

ТЭЗҮ батлагдаагүй:

- 4.3.1.16.Архангай аймгийн Донгойн давааг 2.5 км хатуу хучилттай болгох авто зам барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.18.Архангай аймгийн Цагаан давааг тойруулан Гурван даваагаар давуулан А0603 дугаартай улсын чанартай авто замтай холбох 32.5 км хатуу хучилттай авто зам барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.23.Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн бэлэн байдлыг хангах /ЗТЯ. 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

Худалдан авах ажиллагаа удааширсан:

- 4.3.1.9.Улаангом-Увс нуур чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто зам барих /Увс аймаг/ /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.22.Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих /ЗТЯ. 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.3.1.24.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/

Зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой:

- 4.3.1.10.Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.12.Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.14.Төв аймгийн Тэрэлж БЦГ-ын (Горхи-0.66 км, Тэрэлж-1.4 км) давааны хатуу хучилттай авто зам барих /ЗТЯ. 0 хувь, үр дүнгүй/

2.45. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн үр дүнд хамаарах ТАХ-ний санхүүжилт бүрэн шийдэгдээгүй мөн шаардлага хангаагүй ТАХ-г УХЖТ-нд төлөвлөснөөс үүдэн ТАХ зорилтот үр дүнд хүрээгүй байна. Иймд тооцоо судалгааны үндсэн дээр жилийн хугацаанд хэрэгжүүлэх боломжтой ТАХ төлөвлөж байх нь зүйтэй.

ТАВ. ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Манай Улс Хүнсний аюулгүй байдлын индексийг тооцох аргачлалыг боловсруулж батлаагүй тул Тэргүүлэх чиглэлийн үр дүнг үнэлэх боломжгүй байна

2.46. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд ХХААХҮЯ-ны хариуцан хэрэгжүүлэх 1 ТЕЗ-ийн үр дүн, 1 хөтөлбөрийн үр дүн хамаарч байна.

Хүснэгт 16 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн /тоо, хувиар/

№	Үзүүлэлт	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	-	-	-	1	1	-	ХХААХҮЯ-1
2	Хөтөлбөрийн үр дүн	-	1	-	-	1	90.0	ХХААХҮЯ-1
	Нийт дүн	-	1	-	1	2		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.47. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг “Хүнсний аюулгүй байдлын индекс”-ийн үзүүлэлтээр үр дүнг тооцохоор баталсан ч манай улсад Хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлал байхгүйн улмаас дээрх үр дүнг тооцох, үнэлэх боломжгүй байна. ХХААХҮЯ уг аргачлалын саналыг боловсруулан ҮСХ-нд хүргүүлэн батлуулах шаардлагатай байна.

2.48. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд ХХААХҮЯ-ны хариуцан хэрэгжүүлэх 5 ТАХ хамаарч байна.

Хүснэгт 17 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн /тоо, хувиар/

№	Үзүүлэлт	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	Төсөл, арга хэмжээ	1	3	-	1	5	74.0	ХХААХҮЯ-3, хамтарсан-2

Эх сурвалж. Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.49. Тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн 1 үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй, хөтөлбөрийн 1 үр дүнгийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн, 5 ТАХ-ээс үр дүнтэй 1, тодорхой үр дүнд хүрсэн 3, үр дүнгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

ТЕЗ-ийн үр дүн:

- 5.1. “Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн “Гол нэр төрлийн 16 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамж” шалгуур үзүүлэлтийн суурь түвшин 92.8%, зорилтот түвшин 95% гэж баталсан нь оновчгүй, 2023 оны гүйцэтгэлээр 47.4%-тай байгаа нь зорилтот үр дүнг хангах боломжгүй байна. /ХХААХҮЯ, 47,4 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

Хөтөлбөрийн үр дүн:

- 5.1.1. “Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг “Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр нэмэгдүүлэх хувь”-иар илэрхийлэхээр баталсан байна. /ХХААХҮЯ, 90, тодорхой үр дүнд хүрсэн/

ТАХ-ний хэрэгжилт:

- 5.1.1.1. “Хүнсний үйлдвэрлэлийн дэмжлэгийг эцсийн үр дүнд чиглүүлж оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх”. /ХХААХҮЯ, 90, тодорхой үр дүнд хүрсэн/
- 5.1.1.2. “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих”. /ХХААХҮЯ, 0, үр дүнгүй/
- 5.1.1.3. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизм хэрэгжүүлэх”. /ХХААХҮЯ, 90, тодорхой үр дүнд хүрсэн/
- 5.1.1.4. “НӨАТ-ын системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, дэмжлэгийг оновчтой болгох цахим системийг хөгжүүлэх”. /ХХААХҮЯ, 100, үр дүнтэй/

- 5.1.1.5. “Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх”. /ХХААХҮЯ, 90, тодорхой үр дүнд хүрсэн/

2.50. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлал байхгүй, “Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнг суурь болон хүрэх түвшнийг хэт өндрөөр төлөвлөсөн, статистик тоон үзүүлэлт гарах хугацаа болоогүй шалтгаанаар үнэлэх боломжгүй байна.


ЗУРГАА. УЛААНБААТАР ХОТЫН ТҮГЖРЭЛ, АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

“Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт болох “хотын хөгжлийн үзүүлэлт /индекс/” 2023 онд 0.5022 болж 83.7 хувьтай үнэлэгдэж зорилтод түвшнийг хангаагүй байна

2.51. Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны а/77 дугаар тушаалаар баталсан “Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал” нь 6 бүлэг 30 шалгуур үзүүлэлтээр тооцдог ба дараах хүчин зүйлс голлон нөлөөлдөг. Тухайлбал:

- “Хүрээлэн буй орчин” бүлгийн индекс 0.0552 пунктээр өссөн (эерэг) нь нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Энэ нь Нийслэлд хүн амын нягтаршил өсөн нэмэгдэж байгаа ч ногоон байгууламжийг бодлогоор дэмжиж байгаатай холбоотой юм.
- “Дэд бүтэц” бүлгийн индекс 0.0377 пунктээр өссөн нь (эерэг) хатуу хучилттай зам талбайн нягтаршил, сайжруулсан ариун цэврийн байгууламжид холбогдсон өрхийн эзлэх хувь, төвлөрсөн дулаан хангамжийн хүртээмж, цахим хэрэглээний түвшин, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.
- “Амьжиргааны зохистой түвшин” бүлгийн индекс 0.0173 пунктээр өссөн нь (эерэг) хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой байна.
- “Боловсрол” бүлгийн индекс 0.0887 пунктээр өссөн нь (эерэг) СӨБ-ын хамран сургалт нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент буурсантай холбоотой байна.
- “Эрүүл мэнд” бүлгийн индекс 0.0488 пунктээр буурсан нь (сөрөг) нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд ногдох), халдварт өвчнөөр өвчлөгчдийн түвшин (10000 хүнд ногдох) буурахгүй байгаатай холбоотой байна.
- “Хувь хүний аюулгүй байдал” бүлгийн индекс 0.0854 пунктээр өссөн нь (эерэг) гэмт хэргийн түвшин буурч, эрүүл, аюулгүй гадна орчин бүрдүүлсэн цэцэрлэг, ЕБС-ийн эзлэх хувь нэмэгдэж, теле хяналтын камерын эзлэх хувь нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дүрслэл 8. Хотын хөгжлийн ерөнхий индекс, дэд бүлгээр



Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

2.52. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 3 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 2 ТЕЗ-ийн үр дүн 12 хувь буюу үр дүнгүй, 10 хөтөлбөрийн үр дүн 52 хувиар эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдсэн байна.

Хүснэгт 18. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн	Хариуцагч байгууллага
---	----------	---	-----------------------

		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт	Үнэлгээний дундаж хувь	
1	ТЕЗ-ийн үр дүн				2	2	12.0	НЗДТГ-1, БОАЖЯ-1
2	Хөтөлбөрийн үр дүн	1	1	6	2	10	52.0	НЗДТГ-1, БХБЯ-1
	Нийт	1	1	6	4	12		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.53. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах 5 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 23 ТАХ-ээс үр дүнтэй 2, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 9, үр дүнгүй 6 буюу нийт ТАХ-ний дундаж үнэлгээ 50 хувьтай буюу зорилтот үр дүн бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 19 Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээ дундаж /хувиар/	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	Төсөл, арга хэмжээ	2	6	9	6	23	50.0	НЗДТГ-14, БОАЖЯ-5,ЗТХЯ-3, БХБЯ-5, ЭХЯ-1,

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.54. “6.1 Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсноос нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд /оргил ачааллын үед/ 13 км/цаг буюу 25 хувиар зорилтод үр дүнд хүрээгүй байна. ТЕЗ-ийн үр дүнд хамаарах дараах хөтөлбөрийн үр дүн, ТАХ нь зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа хангалтгүйгээс зорилтот үр дүнд хүрээгүй байна.

2.55. “6.1 Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 15 ТАХ-ний хэрэгжилт нь үр дүнтэй 1, тодорхой үр дүнд хүрсэн 2, ТЭЗҮ, зураг төсөл дуусаагүй, гэрээ хэлэлцээр удааширсан, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, санхүүжилтийг шийдвэрлээгүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалт хангалтгүй зэрэг шалтгаанаар зорилтот үр дүнд хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай 8, үр дүнгүй 4 ТАХ байна. Тухайлбал:

6.1.1. “Авто замын ачааллыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 6.1.1.2. “RFID системийг бүрэн нэвтрүүлэх” арга хэмжээ RFID системийг нэвтрүүлж нийслэлийн хэмжээнд 442477 авто машинд RFID tag суурилуулахаас 258160 буюу 58.3 хувьд суурилуулсан нь зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 58.3 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

6.1.2. “Авто машингүй зорчих замын хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 6.1.2.2. “Дугуйн зам барих” арга хэмжээний хүрээнд 2024 онд Нийслэл Улаанбаатар хотын дугуйн замын сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд нийт 8 байршилд 7.334 км дугуйн замын ажлыг гүйцэтгэсэн нь 58.2 км дугуйн зам барих зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

6.1.3. “Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрт хамаарах:

- 6.1.3.1 “Автобусны богино эргэлтийн терминал байгуулах /Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрд/” арга хэмжээг ЭЗХЯ-ны захиалгаар Нийслэлийн нийтийн тээврийн терминал нэг маягийн 2 зураг төсөл гүйцэтгэх тендерийн гүйцэтгэгчийг шалгаруулан 2023 оны 08 дугаар сард гэрээ байгуулан ажиллаж байсан ч сонгосон байршлуудын газар чөлөөлтөд шаардагдах хөрөнгө төсөвт суугаагүй шалтгаанаар ажлыг зогсоосон нь 3 терминал байгуулах зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

- 6.1.3.2. “Нийтийн тээврийн 1-р эгнээний авто замыг өргөтгөх” ТАХ-ний хувьд ЭЗХЯ-ны захиалгаар хэрэгжүүлж буй ТХААГ-аас зарласан “Нийтийн тээврийн нэгдүгээр эгнээний замын ажлын ТЭЗҮ, зураг төсөл”-ийн ажлын хүрээнд 31.9 км урттай 5 багц буюу Нийслэл Улаанбаатар хотын 5 байршилд (Чингэлтэйн өргөн чөлөө 8.1 км), (Шархадны зам 3.3 км), (Нарны зам 9.4 км), (Энхтайвны гүүрийн 2 түвшний уулзвар, буцах эргэлт, 1.5 км, АПУ-ийн уулзвар орчим, 0.3 км, Мишээл экспогийн хойд талд 0.5 км), (Улиастайн зам 8.8 км) ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил 50-70 хувийн хэрэгжилттэй байгаа нь 31.9 км зам өргөтгөх зорилтот үр дүнд хүрээгүй байна. /НЗДТГ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 6.1.3.4. “Нийслэлд тусгай замын автобусны сүлжээ байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /BRT/” арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдаж эхлээгүй, нарийвчилсан судалгааны үе шатанд явагдаж байгаа нь барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 10 хувь, үр дүнгүй/

6.1.4. “Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно” хөтөлбөрт хамаарах

- 6.1.4.1. “Шинэ тойрог зам” барих төслийн урд хэсэг, Туулын 35 км авто замын барилга барих” арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийн ажил хийгдээгүй учир барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй. /ЗТХЯ, 0 хувь, үр дүнгүй/

2.56. 6.2. “Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгээр Улаанбаатар хотын агаар дахь хүйтний улирлын гол бохирдуулах бодис PM2.5 тоосонцор дундаж агууламж 2024 онд 46 мкг/м³ байгаа нь 2023 оны 41 мкг/м³ харьцуулахад 5 нэгжээр их, зорилтот түвшнээс 15 мкг/м³ нэгжээр их буюу үр дүнг хангаагүй байна.

2.57. Мөн Агаарын чанарын стандарт /MNS4585:2016/ хүлцэх агууламж, PM2.5 тоосонцор 50 мкг/м³ байхаас 2024 оны 1 сард 114 мкг/м³ байгаа нь стандартаас 64 мкг/м³ нэгжээр буюу 2.2 дахин их байгаа нь УБ хотын хүн амын 2023 оны жилийн эцэст 1.734.8 мянган хүнтэй болж өмнөх оноос 0.6 хувиар өссөн байна.

2.58. 6.2. Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 8 ТАХ-ний хэрэгжилт нь үр дүнтэй 2 ТАХ, тодорхой үр дүнд хүрсэн 4 ТАХ, эрчимжүүлэх шаардлагатай 1 ТАХ, үр дүнгүй 1 ТАХ байна. Тухайлбал:

6.2.1. “Инженерийн бүрэн хангамжтай сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрээнд

- 2024 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 ТАХ-ний бүтээн байгуулалтын инженерийн дэд бүтцийн байгууламжийн ажлын явц дунджаар 56.2% байна. Тодруулбал Солонго 1.2 төсөл 37.1%, Залуус 1 төсөл 67.7%, Ногоон нуур 1008 төсөл 63.8%. /БХБЯ, 56.2 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/

6.2.2. “Гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулна” хөтөлбөрийн хүрээнд

- 6.2.2.2. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хоёр дугаар үе шатыг хэрэгжүүлэх” арга хэмжээний хэрэгжилт төслийн II үе шатны хүрээнд Баянхошуу дэд төвд зайлшгүй шаардлагатай нийгмийн барилга байгууламжуудын ажлыг гүйцэтгэж, хэрэгжилтийн явц 82.5 хувьтай байна. Мөн төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд хэрэгжилтийн явц 51.3 хувь байна. Төслийн II үе шатны хэрэгжилтийн явц 56.4% байгаа нь төслийн үе шатыг 80% хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/
- 6.2.2.3. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн гуравдугаар үе шатыг хэрэгжүүлэх” арга хэмжээний хэрэгжилт төслийн III үе шатны хүрээнд Толгойт дэд төвийн нийгмийн болон инженерийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 44.7%-тай байгаа нь, төслийн үе шатыг 60%-д хүргэх зорилтот үр дүнд хүрээгүй. /НЗДТГ, 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

2.59. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнд хамаарах ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл дуусаагүй, гэрээ хэлэлцээр удааширсан, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй, санхүүжилтийг шийдвэрлээгүй, хамтран хэрэгжүүлэгч

байгууллагын хамтын ажиллагаа, зохион байгуулалт хангалтгүй зэрэг шалтгаанаар тухайн ТАХ-ний хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй байна. Иймд УХЖТ-нд тусгах ТАХ-ний хэрэгжилтийг хангахуйц шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцоо судалгааны үндсэн дээр төлөвлөж байх нь зүйтэй.

ДОЛОО. ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

“Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хүрээнд 2024 оны Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж үзүүлэлт гараагүй тул тус шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна

2.60. Засаглалын үзүүлэлтийг “Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж”-ийг 1. Улс төрийн тогтвортой байдал 2, Засгийн газрын үр дүн, 3. Иргэдийн дуу хоолой ба хариуцлага, 4. Зохицуулалтын чанар, 5. Хууль дээдлэх ёс, 6. Авлигын үзүүлэлт гэсэн 6 чиглэлээр гаргадаг ч Дэлхийн банкны засаглалын дундаж үзүүлэлтийг жил бүрийн 6 дугаар сард гаргадаг байна. Иймд тэргүүлэх чиглэлийг үнэлэх боломжгүй байна.

2.61. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах” тэргүүлэх чиглэлд хамаарах 10 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 5 ТЕЗ-ийн үр дүн 47.7 хувь, 12 хөтөлбөрийн үр дүн 64.9 хувийн биелэлттэй зорилт үр дүн эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 20 “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн	1	1	1	2	5	47.7	ЗГХЭГ-2, БХЯ-1, ХЭҮК -1, ШШЕГ-1.
2	Хөтөлбөрийн үр дүн	5	3	-	4	12	64.9	МУШС, ОБЕГ-1, ЗГХЭГ-1, ТӨБЗГ-1, БХЯ-2, ХЗДХЯ-3, ХХЕГ-1, ЦХХХЯ-2, АТГ-1.
Нийт дүн		6	4	1	6	17		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.62. Харин “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд үр дүнтэй 7, тодорхой үр дүнд хүрсэн 7, эрчимжүүлэх шаардлагатай 4, үр дүнгүй 2 буюу нийт 20 ТАХ-ний үнэлгээний дундаж 69.8 хувьтай байна.

Хүснэгт 21 “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн /тоо, хувь/

№	Үзүүлэлт	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт		
1	Төсөл, арга хэмжээ	7	7	4	2	20	69.8	МУШС-1, ЗГХЭГ-4, БХЯ-2, ХЗДХЯ-7, АТГ-1, ЦХХХЯ-3, ГХЯ-1, СЗХ-1

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.63. ТЕЗ-ийн үр дүнд хамаарах 5 ТАХ-ний хэрэгжилт нь үр дүнтэй 1, тодорхой үр дүнд хүрсэн 1, эрчимжүүлэх шаардлагатай 1, үр дүнгүй 2 ТАХ байна. Үр дүнтэй 1 ТАХ нь 7.1 “7.5. Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ” ТЕЗ-ийн ажлыг төлөвлөхдөө ЭЗХЯ-аас шалгуур үзүүлэлтийг үндэслэлгүй тогтоосон. ТЕЗ-ийн үр дүнгийн нэр “Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ”, ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд “Шүүхийн сахилгын хороонд гаргасан гомдлын тоогоор” гэж төлөвлөсөн нь хоорондоо уялдаагүй байна. Тухайлбал:

- Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн сахилгын хороо нь шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага юм. Харин Шүүх шинжилгээний байгууллага нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай чиг үүрэг бүхий төрийн тусгай алба юм.
- Иймээс ТЕЗ тус ажлын хэрэгжилтийг үнэлэхдээ Шүүхийн сахилгын хороонд гаргасан гомдлын тоогоор авч үзэж 100 хувьтай үнэлсэн нь үндэслэлгүй бөгөөд үр дүнгүй.

2.64. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнгийн хөтөлбөрийн 7.3 Хүний эрхийн зөрчлийг бууруулна” төсөл арга хэмжээний хэрэгжилт /ХЗДХЯ. 0 хувьтай үр дүнгүй байна. Үүнд:

- “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдал хангагдана” хөтөлбөрийн үр дүнг “Нийт үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд, гэр бүлээс үйлчилгээ авсан хүүхэд, гэр бүлийн эзлэх хувь”-ийг 85 хувийн зорилтот түвшинд хүргэнэ гэж төлөвлөсөн байна. Нийт үйлчилгээ авах шаардлагатай иргэдийн тоог урьдчилж тооцоолдоггүй ба уг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг алдаатай төлөвлөснөөр зорилтын үр дүн хангагдахгүйд хүрч байна.

НАЙМ. НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

“Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт “байгаль орчны гүйцэтгэлийн индекс”-ээр 2024 онд 180 орноос 143 дугаарт эрэмбэлэгдсэн нь 48 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн байна

2.65. Уг индексийг БНСУ-ын Иелийн их сургуулиас 11 ангилал бүхий 58 үзүүлэлтийг бодлогын гурван зорилтод хуваан, тус бүрийн хувийн жингээр тодорхойлдог.

Хүснэгт 22 “Байгаль орчны гүйцэтгэлийн индекс”-ийн үндсэн 3 ангиллын үзүүлэлт

Үндсэн үзүүлэлт	Эрэмбэ	Оноо	Индексэд эзлэх	
			Хувийн жин	Оноо
Эко системийн амьдрах чадвар	68-р байр	55.2	45%	24.8
Хүрээлэн буй орчны эрүүл мэнд	140-р байр	28.5	25%	7.1
Уур амьсгалын өөрчлөлт	170-р байр	17.6	30%	5.3
Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	143-р байр			37.2

Эх сурвалж: БНСУ-ийн Иелийн их сургуулийн судалгаа /2024 Environmental Performance Index - Mongolia/

2.66. “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлд хамаарах БОУАӨЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн 1 ТЕЗ-ийн үр дүн 48 хувиар “эрчимжүүлэх шаардлагатай”, 4 хөтөлбөрийн үр дүн 80 хувийн биелэлттэй зорилтот үр дүнг хангасан байна.

Хүснэгт 23 Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, хөтөлбөрийн үр дүн

№	Үзүүлэлт	Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээний дундаж хувиар	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	ТЕЗ-ийн үр дүн			1		1	48.0	БОУАӨЯ-1
2	Хөтөлбөрийн үр дүн	1	2	1		4	80.0	БОУАӨЯ-4
	Нийт дүн	1	2	2		5		

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.67. Харин “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 3 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 8 ТАХ-ээс 6 ТАХ тодорхой үр дүнд хүрч, 2 ТАХ эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй үнэлэгдэж, дундаж үнэлгээ 77 хувьтай байна.

Хүснэгт 24 Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн

№	Үзүүлэлт	Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлийн үр дүн			Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	

		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт	Үнэлгээний дундаж хувиар	
1	Төсөл, арга хэмжээ	4	2	1	1	8	77.0	БОУАӨЯ-8, ХББОСЯ-1, НЗДТГ-1

Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.68. 8.1. “Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална” ТЕЗ-ийн үр дүн болон 8.1.3.“Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүн зорилтот түвшинд хүрээгүй буюу “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн байна.

2.69. Харин 12 шалгуур үзүүлэлт бүхий 11 хөтөлбөр, ТАХ-ний үр дүн зорилтот түвшинд хүрсэн буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, “үр дүнтэй” үнэлэгдсэн байна. Тухайлбал:

8.1.“Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах:

8.1.1“Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ” хөтөлбөр /БОУАӨЯ. 99 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

- 8.1.1.1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх” арга хэмжээ 3 шалгуур үзүүлэлттэй /БОУАӨЯ. 100 хувь, үр дүнтэй/
- 8.1.1.2.“Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах” арга хэмжээ /БОУАӨЯ. 100 хувь, үр дүнтэй/

8.1.2.“Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” хөтөлбөр /БОУАӨЯ. 100 хувь, үр дүнтэй/

- 8.1.2.1.“Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээ /БОУАӨЯ. 100 хувь, үр дүнтэй/
- 8.1.2.2.“Улаанбаатар хотын хог хаягдлыг дахин боловсруулах төсөл хэрэгжүүлэх” арга хэмжээ /НЗДТГ. 100 хувь, үр дүнтэй/
- 8.1.2.3.“Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих” арга хэмжээ /ХББОСЯ. 73.7 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

8.1.4.“Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” хөтөлбөр 2 шалгуур үзүүлэлттэй /БОУАӨЯ. 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

- 8.1.4.1.“Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээ /БОУАӨЯ. 90 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

2.70. “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ болон хөтөлбөрийн үр дүн дунджаар 81,5 хувьтай үнэлэгдэж байгаа ч ТЕЗ болон тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт ижил байгаа нь тохиромжгүй байна. Мөн “байгаль орчны гүйцэтгэлийн индекс” нь жил бүр гардаггүй тул Монгол улс дотооддоо үнэлэх аргачлал боловсруулах шаардлагатай байна.

УХЖТ-нд тусгагдсан тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна

2.71. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа”-г баталсан байна. Тус журмын дагуу ТЕЗ нар хэрэгжилтийн тайланг хүргүүлэхдээ 3 байгууллага хугацаа хоцроон хүргүүлсэн, 1 байгууллага огт тайлагнаагүй, төрийн мэдээллийн системд 6 байгууллага хугацаа хоцроон хэрэгжилтийг тайлагнасан байна. Энэ нь ЭЗХЯ, ЗГХХГ-аас дараах хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээг хийх боломжгүй үр дагаврыг бий болгожээ. Тухайлбал:

Монголбанкны хариуцан хэрэгжүүлж буй 1 хөтөлбөрийн үр дүн, 1 төсөл, арга хэмжээ:

- 2.1.2. “Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүн,
- 2.1.2.1. “Банкны салбарын реформыг хэрэгжүүлж, гадаадын банкны салбар байгуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” төсөл арга хэмжээ


Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын хариуцан хэрэгжүүлж буй 1 хөтөлбөрийн үр дүн, 2 төсөл, арга хэмжээ:

- 7.2.4. “Газрын харилцааны үйлчилгээг хялбаршуулна” хөтөлбөрийн үр дүн,
- 7.2.4.1. “Газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх”,
- 7.2.4.2. “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх” 2 төсөл, арга хэмжээ

2.72. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайланг 2025 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор УАГ-т ирүүлэх гэж холбогдох журамд заасны дагуу ЗГХХГ-аас тайланг ирүүлэхдээ зөвхөн төсөл, арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийсэн байна. Харин Тэргүүлэх чиглэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, Хөтөлбөрийн үр дүнгийн тайланг хугацаа хоцроож буюу 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн байна.

2.73. УХЖТ-нд тусгагдсан 194 ТАХ-г хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ аудитын багийн тайлагнаснаар 6,401.1 тэрбум төгрөг, Засгийн газрын тайлагнаснаар 4,274.1 тэрбум төгрөг байна. Үүнийг тэргүүлэх чиглэлийн хүрээнд ангилж үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 9. УХЖТ-нд тусгагдсан Тэргүүлэх чиглэлийн хүрээнд зарцуулсан ТАХ-ний гүйцэтгэл тэрбум.төгрөг



Эх сурвалж: Аудитын багийн судалгааны нэгтгэл

2.74. Дээрх санхүүжилтийн гүйцэтгэлээс харахад “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн дүн өндөр байгаа нь Засгийн газрын тайлагнал үнэн зөв, бодитой бус байгааг харуулж байна. Тухайлбал:

2024 онд уг ТАХ-г хэрэгжүүлэхтэй холбоотой ямар нэг хөрөнгө гараагүй бөгөөд УХЖТ-нд батлагдсан санхүүжилтийн дүнг Засгийн газар тайлагнасан:


- 2.2.3.3.Гангийн үйлдвэр байгуулах /АҮЭБЯ-1,000.0 тэрбум төгрөг/
- 2.2.3.4.Ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах /БоЯ, АҮЭБЯ-1,000.0 тэрбум төгрөг/
- 7.2.4.1.Газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх /ЗГХЭГ-ГЗБГЗЗЕГ-26.9 тэрбум төгрөг/
- 7.2.4.2.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх /ЗГХЭГ-ГЗБГЗЗЕГ-1.6 тэрбум төгрөг/

2024 онд уг ТАХ-г хэрэгжүүлэхтэй холбоотой зарцуулсан хөрөнгийг Засгийн газраас тайлагнаагүй:

- ТӨҮГ болон өөрийн хөрөнгөөр зарцуулсан “2,408.3” тэрбум төгрөг
- Орон нутгийн төсвөөс зарцуулсан “387.2” тэрбум төгрөгийг тус тус тайлагнаагүй байна.

2.75. Аудитын баг болон Засгийн газрын тайлагналаар УХЖТ-нд тусгагдсан ТАХ-г хэрэгжүүлэхэд нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээг 2,127.0 тэрбум төгрөгийн зөрүүтэй байна. Үүнийг тэргүүлэх чиглэлээр ангилж үзэхэд дараах байдалтай байна.


Дүрслэл 10. Нийт зарцуулсан хөрөнгийн тайлагналын зөрүү. /тэрбум.төгрөг/



2.76. Дээрх дүрслэлээс харахад “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлд зарцуулсан хөрөнгө их хэмжээний зөрүүтэй байгаа нь Засгийн газар Улсын төсвөөс НДС-д шилжүүлэх “1,175.0” тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс дугуйн болон явган хүний зам барихад санхүүжүүлсэн “387,2” тэрбум төгрөг, БНСУ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Солонго-1,2 төслийн ГЗТ болон Монгол талаас санхүүжүүлэх хөрөнгийн “350.8” тэрбум төгрөгийг тус тус тайлагнаагүйтэй холбоотой байна.

2.77. Аудитын багийн тайлагнасан 6,401.1 тэрбум төгрөгийн зарцуулалтыг эх үүсвэрээр нь ангилж үзвэл:

Дүрслэл 11. УХЖТ-нд тусгагдсан ТАХ-ний хөрөнгийн зарцуулалт. тэрбум.төгрөг



2.78. ТЕЗ болон хөтөлбөрийн үр дүнг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан нийт 34.3 тэрбум төгрөгийн зарцуулалтыг Засгийн газар огт тайлагнаагүй байна. Тухайлбал:

ТЕЗ-ийн үр дүн:

- 6.2 Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ /БОУАӨЯ-урсгал зардал, 18.3 тэрбум төгрөг/

Хөтөлбөрийн үр дүн:

- 6.1.4. Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно /НЗДТГ-Гадаадын тусламж, 16.0 тэрбум төгрөг/
/Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл болон аудитын багийн судалгааны нэгтгэл/

2.79. УХЖТ-нд тусгагдсан тэргүүлэх чиглэлийн үр дүнг хангахад чиглэсэн ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, зарцуулсан хөрөнгийг журмын дагуу холбогдох хавсралтаар үнэн зөв, бодитой тайлагнаагүй нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө болон зарцуулсан хөрөнгийн үнэ цэнийг бий болгож чадахгүй байна.

УХЖТ-нд туссан ТАХ-ний санхүүжилтийн зарцуулалтын иж бүрэн байдлыг Шилэн дансны нэгдсэн системээс шалгахад хүндрэлтэй байна

2.80. Төрийн байгууллагуудын санхүүгийн ил тод байдал, шилэн дансны харилцааг Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-аар зохицуулж байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд" буюу төсвийн ерөнхийлөн захирагчдын мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих мэдээ, тайлангаас 6.4.4-т заасан "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-т заасан "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ"-ний мэдээ тайланг байршуулсан байдлыг шалгахад хугацаа хоцроосон зүйл байхгүй байгаа ч УХЖТ-нд туссан ТАХ-нд зарцуулсан хөрөнгө, ХАА-тай холбоотой мэдээллийг Шилэн дансны нэгдсэн системд байршуулснаас гүйцэтгэлийг шалгахад хүндрэлтэй байгаа нь ТАХ-нд зарцуулсан хөрөнгийг ил тод, нээлттэй иж бүрэн мэдээлсэн эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.81. Сангийн яам нь Төсвийн ерөнхийлөн захирагч нарын шилэн дансанд хийсэн хяналт шалгалтын тайланг цаасаар болон цахимаар хүлээн авч нэгтгэн, нийт 62 ТЕЗ-ийн шилэн дансны хэрэгжилтийг 89.4-98.8 хувиар /дундаж үнэлгээ 95.7 хувь/ үнэлж нэгтгэсэн тайланг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

Нотлох баримтад суурилсан цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна

2.82. ЗГХХГ, ЭЗХЯ нь бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхдээ нотлох баримтад үндэслэж мэдээлэл цуглуулах, нэгтгэх, үр нөлөө, гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөлөл, төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх, төлөвлөлт болон хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах зэрэг цогц хяналт-шинжилгээ үнэлгээг хийж чадаагүй байна. Тухайлбал:

1. Тайлагналыг хариуцаж байгаа байгууллага бодитой тайлагнадаггүй:

- 2.3 “Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнг хариуцан хэрэгжүүлэгч байгууллага буруу тайлагнасан байгааг ЭЗХЯ 100 хувь, үр дүнтэй гэж үнэлсэн нь аудитын үнэлгээгээр 50 хувь, эрчимжүүлэх шаардлагатай;
- 7.5 “Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ” үр дүнгийн хүрээнд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага буюу ХЗДХЯ-аас буруу мэдээлэл тайлагнасныг ЭЗХЯ-аас 100 хувь, гэж үнэлгээг хийсэн байна.

2. Нотлох баримтад үндэслэхгүйгээр үнэлгээг хийсэн:

- Төрийн мэдээллийн системд төсөл, арга хэмжээг хариуцан тайлагнаж байгаа 23 ТЕЗ байгаагаас нотлох баримтыг системд бүрэн оруулсан 5, дутуу оруулсан 8, огт оруулаагүй 10

байгууллага байгаа нь нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийж чадахгүй байх нөхцөл байдлыг үүсгэжээ.

- 2.1.1.1. “Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлэх” төсөл арга хэмжээ /ЗГХХГ 0 хувь, үр дүнгүй/
- 4.3.1.7. “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км” төсөл арга хэмжээ /ЗГХХГ 100 хувь, үр дүнтэй/
- 4.3.1.11. “Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100-200 км тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах /амрах өртөө/” төсөл, арга хэмжээ /ЗГХХГ 70 хувь, тодорхой үр дүнд хүрсэн/

3. Хөтөлбөрийн үр дүн, ТЕЗ-ийн үр дүнг тайлагнах хэсэгт нотлох баримт хавсаргах хэсэг байхгүй нь үнэлгээг зөвхөн тайлагналд үндэслэн хийх нөхцөлийг бий болгосон байна. Тухайлбал:

Хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд:

- 3.2.1. “Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд “Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа” шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ ЭЗХЯ 100 хувь, үр дүнтэй гэсэн нь нотлох баримтаар дэмжигдээгүй буюу аудитын үнэлгээгээр 89.1 хувь, тодорхой үр дүнд хүрсэн байна.
- 3.3.3. “Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд Иргэдийн бие бялдрын ерөнхий хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох судалгаагаар нийт хүн амын 29.0 хувь хөдөлгөөний хомсдолтой гарч 0 хувь, үр дүнгүй байгааг ЭЗХЯ 100 хувь, үр дүнтэй гэж үнэлсэн байна.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх цаг хугацаа болон хүний нөөцөөс хамаарч

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу УХЖТ-ний хэрэгжилтэд 15 хоногийн дотор хяналт-шинжилгээ үнэлгээг ЭЗХЯ болон ЗГХХГ-аас хийхдээ хүний нөөцийн чадамж, хүрэлцээ дутмаг, зохион байгуулалт хангалтгүй, цаг хугацааны нөлөөлөл, нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхгүй байгаа нь үнэн зөв бодитой үнэлэгдэхгүй байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас алдаа, зөрчил давтагдаж байна

2.83. Улсын хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 2022 онд 10 зөвлөмж, 2023 онд 9 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 25. Аудитаар өгсөн зөвлөмжийн мэдээлэл

№	2022 он	Зөвлөмжийн тоо	2023 он	Зөвлөмжийн тоо
1	Монгол Улсын Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайдад	5	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад	2
2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сангийн сайдад	1	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	2
3	Үндэсний статистикийн хорооны даргад	2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт	2
4	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	2	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нарт	1
5			Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	2

Эх сурвалж” УАГ-ын Улсын хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн”-нд хийсэн аудитын тайлан

2.84. Улсын хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 2022 онд 27 ТЕЗ, 2023 онд 22 ТЕЗ нарт тус тус хоёр зөвлөмж өгсөн байна.

2.85. ТЕЗ нараас 2022 онд 15 ТЕЗ, 2023 онд 12 ТЕЗ зөвлөмжийн хэрэгжилт ирүүлээгүй байгаа нь хангалтгүй байна.

Хүснэгт 26. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн мэдээлэл

Он	2022, 2023 онд аудитаар өгсөн зөвлөмжийн		
	ТЭЗ-ийн тоо	Хэрэгжилт ирүүлсэн	Хэрэгжилт ирүүлээгүй
2022	22	12	15
2023	27	10	12

Эх сурвалж: ТЭЗ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт ирүүлсэн албан бичиг

2.86. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийг хангахад бүртгэх, тайлагнах, үнэлэх үйл явцад ахиц гарахгүй байхад нөлөөлж байна. Тухайлбал,

2.87. 2023 оны “Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн гүйцэтгэлийн аудитын дүнгээр ЭЗХЯ-д өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй бөгөөд ХБТТУТХ-ийн 22.1-д заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулах мэдээллийн нэгдсэн санг (<https://development.gov.mn/>) бүрэн хэрэгжүүлээгүй байна. Энэхүү системийг бодлогын баримт бичгийг боловсруулахад ашиглахгүй байна.

2.88. Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналд “Хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан” (unelgee.gov.mn) системийг ашиглаж байгаа боловч уг систем нь 2012 онд РНР хэл дээр хийгдсэн “Монолитик” архитектуртай, дэвшилтэд мэдээлэл технологийн сангууд ашиглаагүй, MySQL өгөгдлийн сангийн мэдээлэл тогтмол нөөцлөгддөггүй зэрэг техникийн хязгаарлалт, аюулгүй байдал, өргөтгөх боломжийн дутагдлаас шалтгаалсан эрсдэлүүд үүсэж болзошгүй байна. Ийм нөхцөлд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдааг хангах, давхардал, хийдлийг арилгах, нэгтгэх, хүчингүй болгох, шинэчлэн боловсруулах ажлууд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх магадлалтай бөгөөд мэдээллийн нэгдсэн санг бүрэн хэрэгжүүлэх, техникийн аюулгүй байдал, өргөтгөх боломжийг нэмэгдүүлэх шаардлага тулгамдаж байна.

2.89. ЗГХХГ нь “Олон улсын үнэлгээний цогц систем”-ийг судалж байгаа бол ҮСХ нь Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолоор “ИХ ӨГӨГДЛИЙН САН”-г бүрдүүлэх чиглэлд 2024 оны төлөвлөгөөнд статистик, татварын мэдээллийг нэгтгэх туршилтыг тусгасан. ҮСХ-ны data.nso.mn “Төрийн нэгдсэн сан” нэртэй өгөгдлийн санд төрийн олон байгууллагын өгөгдөл нэгдсэн байна.

2.90. Зөвлөмжийг чанартай хэрэгжүүлэхгүй байгаагаас алдаа зөрчил давтагдаж байна. Тухайлбал:

Дүрслэл 12 Зөвлөмжөөр өгсөн зөрчил аудитаар давтан гарсан талаарх мэдээлэл



Эх сурвалж: УАГ-ын Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаа

2.91. Дээрх зөрчлүүд дахин давтагдан гарч байгаа нь зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, ТЕЗ нар зөвлөмжийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх үүргээ анхааран авч үзэхгүй байгаагаас төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжих боломжгүй үр дагавар үүсгэж байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгээр дунд хугацааны бодлогын зорилт, үйл ажиллагааны 2025 оны үр нөлөө, ахицыг бүрэн үнэлж дүгнэх боломжгүй байна


2.92. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан 8 бодлогын¹² 8 зорилгын 21 зорилтын үр дүнг хангахад чиглэсэн зарим үйл ажиллагааг, хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтээс 38 шалгуур үзүүлэлтийг Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 7 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 ТЕЗ-ийн үр дүн, 13 хөтөлбөр, 12 ТАХ-ний хүрсэн түвшин, биелэлт нь дунд хугацааны бодлогын зорилтын үр дүнд шинжилгээ хийлээ. Үүнд:

Нэг.Экспортыг нэмэгдүүлэх” тэргүүлэх чиглэл:

2.93. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Экспортыг нэмэгдүүлэх” тэргүүлэх чиглэлийн хамаарах 3 хөтөлбөр, 1 ТАХ нь дунд хугацааны “Эдийн засгийн” бодлогын зорилт 4.2¹³-ын 4.2.9, Зорилт 8.1¹⁴-ийн 8.1.5, 8.1.8 үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

Дүрслэл 13. Гадаад худалдааны нийт эргэлт дэх экспортын хэмжээ

2.94. Гадаад худалдааны нийт эргэлтээр экспортын хэмжээг 2024 оны хүрсэн түвшин 15783 сая.ам доллар буюу 2025 онд 14020 сая.ам.долларт хүргэх үр дүнг 12.6 хувийн өсөлттэй эерэг ахицыг бий болгосон байна.



Эх сурвалж: 1212.mn

2.95. Харин 2024 оны 2 хөтөлбөрийн үр дүнгээр 2024 онд шинээр баригдсан төмөр зам 394.6 км, шинээр баригдсан улсын чанартай авто зам 495.9 км болж 2025 онд “шинээр баригдах төмөр замын урт” 1174 км-ын 33.6 хувь, “шинээр баригдах улсын чанартай авто замын урт” 2022 км-ын 24.5 хувийг эзэлж байгаа нь дунд хугацааны зорилтын үр дүнг хангахааргүй байна.

2.96. Мөн 2025 онд “Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийн тоо” 10 гэж тусгасан ч 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 1.3.1.” Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг бий болгоно” хөтөлбөрийн хүрээнд Шинэ ховд УТП-ийн дэд бүтцийн ажил 58 хувь, Налайх УТП-ийн дэд бүтцийн ажил 90 хувь, Багануур дүүргийн УТП-ийн дэд бүтцийн ажил 89 хувь, Бага хангай УТП-ийн дэд бүтцийн ажил 90 хувь, Эмээлт эко УТП-ийн дэд бүтцийн ажил 10 хувь, Дархан арьс шир дэд бүтцийн ажил хийгдээгүй нь дунд хугацааны зорилгоо хангах боломжгүй байна.

Хоёр. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэл:

2.97. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” тэргүүлэх чиглэлд хамаарах 1 хөтөлбөр, 1 ТАХ нь дунд хугацааны “Эдийн засгийн” бодлогын

12 “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Эдийн засаг”, “Засаглал”, “Ногоон хөгжил”, “Амар тайван, аюулгүй нийгэм”, “Бүс, орон нутгийн хөгжил”, “Улаанбаатар ба дагуул хот”


13 Зорилт 4.2.Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:

14 Зорилт 8.1.Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно

зорилт 4.1¹⁵-ийн 4.1.1. “...гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ” үйл ажиллагаа, зорилт 4.4¹⁶-ийн 4.4.2. “гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ” үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

Дүрслэл 14. Уул уурхайн салбар, боловсруулах үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь

2.98. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2024 оны III улирлын гүйцэтгэлээр 2.9 тэрбум.ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26.9 хувийн өсөлт гарсан нь “Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь” 2024 онд 27.9 хувийг эзэлж байгаа нь 2025 оны хүрэх түвшнээс 2.74 хувийн, Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2024 онд 6.7 хувийг эзэлж байгаа нь 2025 оны хүрэх түвшнээс 5.26 хувийн хүлээлтийг бий болгож байна.



Эх сурвалж. 1212.mn

2.99. Харин Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 2.1.3.1. “Бүгд Найрамдах Солонгос Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах” болон 2.1.3.3. “Тайландын Хаант улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс, Бүгд Найрамдах Энэтхэг улсуудтай Хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах” арга хэмжээ нь холбогдох хэлэлцээр байгуулах ажлын үр дүн бүрэн хангагдаагүйгээс 2025 оны 4.4.2-т “гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ” үйл ажиллагааны хэрэгжилт хангагдахгүй байх нэг нөхцөл болж байна.

Гурав. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэл:

2.100. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах 3.2.2¹⁷ хөтөлбөрийн 3.2.3.1 “Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх”, 3.3.3.1 “Парис-2024” зуны олимп, паралимпын наадамд болон олимпын эрхийн төлөөх тэмцээнүүд, бусад олон улсын тэмцээнд оролцох” 2 төсөл арга хэмжээний хэрэгжилт нь дунд хугацааны “2. Хүний хөгжил”, “3. Амьдралын чанар ба дундаж давхарга” бодлогын 2.6.5, 3.5.4, 3.1.1 зорилтын үйл ажиллагаатай зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Тухайлбал:

- 3.2.3.1. “Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх” ТАХ-ний хүрээнд 2024 онд ТАХ-ын цалинг 10.0-11.1 хувиар нэмэгдүүлж, зорилтот үр дүнг хангаж, ЗГ-ын 2024.12.25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхээр баталсан нь 2025 оны зорилтот үр дүнд хүрэх шийдвэр болсон байна.
- 3.1.3.1. “Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах” ТАХ-ний хүрээнд 2024 онд 108 шинэ бүтээл бүртгэсэн бөгөөд 2025 онд Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан бүтээлийн тоо 500-д хүрэх үр дүнгээс 392 бүтээлийн хүлээлт үүсгэж байна.

2.101. Эдгээр үзүүлэлтүүд нь 2021-2025 оны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний зорилттой нийцэж буй боловч нийгмийн халамжийн тэтгэвэр, амьжиргааны доод түвшний харьцаа буурсан нь анхаарал хандуулах шаардлагатай асуудал болж байна.

15 Зорилт 4.1. Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ

16 Бүс нутгийн хамтын ажиллагаа Зорилт 4.4. Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евроазийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.

17 “Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэх” хөтөлбөрийн үр дүн

Дөрөв. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэл:

2.102. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах 4.2-т “Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүн, 4 ТАХ нь дунд хугацааны “Эдийн засгийн” бодлогын зорилт 4.2¹⁸-ын 4.2.10. “агаарын тээврийн либералчлал хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлсэн байна” үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн ч 2025 онд “Олон улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоог 3 болгох үр дүнг хангах нөхцөл бүрдээгүй байна.

2.103. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 4.2.1. “Нислэгийн тоог нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй дараах 4 арга хэмжээ нь Концессын тухай хууль ТХХТТХ-ийн 17.1.2. “түншлэлээр хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээг хийх, үнэлэх үе шат”-ыг бүрэн хангаагүйгээс хэрэгжилт үр дүн гараагүй байна.

- 4.2.1.2.Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах, /ЗХЯ, Охувь, үр дүнгүй/
- 4.2.1.3.Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах, /ЗХЯ, Охувь, үр дүнгүй/
- 4.2.1.4.Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах, /ЗХЯ, 0 хувь, үр дүнгүй/
- 4.2.1.5.Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлыг 4С ангилалд нийцүүлэх, /ЗХЯ, 0 хувь, үр дүнгүй/

Тав. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэл:

2.104. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Өвчлөл, нас баралтыг бууруулна” ТЕЗ, 5.1.1.“Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүн нь дунд хугацааны “Бүс, орон нутгийн хөгжил” бодлогын Зорилго 8¹⁹-ын зорилт 8.3²⁰-ын 8.3.1-ийн үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн “Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнг суурь болон хүрэх түвшнийг хэт өндрөөр алдаатай төлөвлөсөн, жилийн тоон үзүүлэлт гарах хугацаа болоогүйгээс үнэлэх боломжгүйд хүрч дунд хугацааны 8.3.1. “гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана” үйл ажиллагааны үр дүн ахицыг дүгнэх боломжгүй болсон байна.
- Мөн “Өвчлөл, нас баралтыг бууруулна” ТЕЗ-ийн үр дүнгээр “Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2024 онд 38.4 промилд хүрч зорилтот үр дүнг хангаагүй бөгөөд дунд хугацааны “Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь” шалгуур үзүүлэлтээр 2025 онд 87.5 хувь хүргэхээр зорилтот үр дүнг тусгасан нь хоорондоо уялдаагүйгээс 2025 оны үр дүн, ахицыг үнэлэх боломжгүй байна.
- 5.1.1. хөтөлбөрийн 5.1.1.2. “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих” арга хэмжээ нь огт биелэгдээгүйгээс 2025 онд “шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг 10 болгох үр дүн биелэгдэх боломжгүй байна.

18 Зорилт 4.2.Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ

19 Зорилго 8.Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.


20 Тогтвортой хөдөө аж ахуй Зорилт 8.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ

Зургаа. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэл:

2.105. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлд хамаарах “Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүн, 3 хөтөлбөрийн үр дүн нь дунд хугацааны 2 бодлого²¹, 2 зорилгын зорилт 8.2²², зорилт 9.2²³, зорилт 9.5²⁴-ын 4 үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

Дүрслэл 15 Хотын хөгжлийн үзүүлэлт

2.106. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2025 онд “Хотын хөгжлийн үзүүлэлт”-ийг 1.Хүрээлэн байгаа орчин, 2.Дэд бүтэц, 3.Амьжиргааны зохистой түвшин, 4.Боловсрол, 5.Эрүүл мэнд, 6.Хувь хүний аюулгүй байдал шалгуур үзүүлэлтийн²⁵ хүрээнд 2025 онд 0.572 индексэд хүргэх зорилттой бөгөөд 2024 оны хүрсэн түвшин 0.502 индекстэй /2023 оны тоо мэдээллээр/ байгаа нь 0.07 индексийн хүлээлт үүсгэж байна.



Эх сурвалж: Нийслэлийн үндэсний статистикийн газрын мэдээ

2.107. “Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнд хамаарах “Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж”-ыг 2025 онд 40 мкг/м³ зорилттой бөгөөд 2024 оны хүрсэн түвшин 46 мкг/м³ байгаа нь 2025 оны үр дүнг хангах боломжгүй болсон байна. Үүнд:

Хүснэгт 27. Агаарын чанарын стандарт хүлцэх агууламж, сарын дундаж мкг/м³

Хүйтний улирлын гол бохирдуулах бодис	Агаарын чанарын стандарт ²⁶ хүлцэх агууламж, сарын дундаж мкг/м ³	2024 оны				2024 оны жилийн дундаж /хүйтний улирлаар/	2025 оны зорилтот түвшин	2025 оны хүлээгдэж буй түвшин
		1 сар	10 сар	11 сар	12 сар			
PM2.5 тоосонцор	50	114	26	44	99	46	40	-6
Хүхэрлэг хий, SO ₂	50	152	37	55	122	61		
PM10 тоосонцор	100	132	87	112	131	82.7		
Азотын давхар исэл, NO ₂	50	72	47	40	57	39.7		

Эх сурвалж: Ус цаг уур орчны газраас гаргадаг “Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдлын тойм” 2024 оны мэдээ

2.108. Дээрх байдал нь УБ хотын хүн амын 2023 оны жилийн эцэст 1.734.8 мянган хүнтэй болж өмнөх оноос 0.6 хувиар өссөн, УБ хотод 2023 онд 32299 хүн шилжин ирсэн нь улсын дүнтэй харьцуулахад 57.5 хувийг эзэлж, нэгж газар нутагт ногдох хүн амын нягтрал 369.1 хүн байгаа төвлөрөл хэт ихэссэн нөлөө үзүүлж байна.

2.109. “Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн хүрээнд 3 хөтөлбөр 2024 оны зорилтот үр дүнд хүрээгүй, Улаанбаатар хотын нийт өрх 2020 онд 414,292 бөгөөд үүнээс төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай

21 Найм.”бүс, орон нутгийн хөгжил” бодлого, Ес.”Улаанбаатар ба дагуул хот” бодлого

22 Аялал жуулчлал Зорилт 8.2. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ:

23 Орчин төвтэй шийдэл Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно:

24 Дагуул хот Зорилт 9.5.Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ

25 Улаанбаатар хотын индекс тооцдог аргачлалын дагуу

26 MNS4585:2016

орон сууцанд амьдардаг өрх 2020 онд 317,799 болж нийт өрхийн 76.7 хувийг эзэлж байсан байна.

2.110. Харин Улаанбаатар хотын нийт хүн ам 1,713.3 мянга, нийт өрх 2023 онд 465,059 болсон бөгөөд өрхийн тоог 2020 онтой харьцуулахад 12.2 хувиар өссөн байна. ҮСХ-оос 10 жил тутамд Хүн ам, орон сууцны тооллого /ХАОСТ/-ын дүнгээр төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог гаргаж байгаа нь 2025 оны зорилтот түвшний хүлээлтийг тооцох боломжгүй байна.

Долоо. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэл:

2.111. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 1 ТЕЗ, 3 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээ нь дунд хугацааны “Амьдралын чанар ба дундаж давхарга” бодлогын зорилт 3.6²⁷-ын 3.6.5, “Эдийн засаг” бодлогын зорилт 4.3²⁸-ын 4.3.4, зорилт 4.6-ын 4.6.1, “Засаглал” бодлогын зорилт 5.6²⁹-ын 5.6.3, “Амар тайван, аюулгүй нийгэм” бодлогын зорилт 7.1³⁰-ийн 7.1.3, зорилт 7.4³¹-ийн 7.4.3, зорилт 7.5³²-ын 7.5.1 үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Дунд хугацааны бодлогын зорилгыг хангахад чиглэсэн “Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө” ТЕЗ-ийн үр дүнгийн үзүүлэлт 2024 оны 6 сард гарах тул үнэлэх боломжгүй байна.
- “Цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг³³ 0.6358 нэгжид хүргэх” үр дүн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд “Төрийн үйлчилгээг цахимаар хүртэгчид”, “Харилцаа холбооны дэд бүтцийн индекс” гэсэн 2 хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэхээр баталсан байгаа нь дунд хугацааны зорилгыг хангахад чиглэгдсэн бөгөөд Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт 0.84 нэгжид хүрч 2025 оны зорилтот түвшинг хангасан байна.

Найм. “Ногоон хөгжлийн дэмжинэ” тэргүүлэх чиглэл:

2.112. Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний “Ногоон хөгжлийг дэмжинэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална” ТЕЗ-ийн үр дүн, “Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ” хөтөлбөр, “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” хөтөлбөрийн үр нь дунд хугацааны “Ногоон хөгжил” бодлогын зорилт 6.2³⁴-ын 6.2.2³⁵ үйл ажиллагааны зарим чиглэлийг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан “Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална” ТЕЗ-ийн үр дүнгийн 2024 оны Байгаль орчны гүйцэтгэлийн индекс Экологийн системийн амьдрах чадвар (68-р байр), Байгаль орчны эрүүл мэнд(140-р байр), Цаг уурын өөрчлөлт (177-р байр), нийт 143 байрт³⁶ эрэмбэлэгдэж 37.2 оноо авсан нь 2025 оны зорилтот түвшин 58 онооноос 20.8 онооны хүлээлт үүсгэж байна.
- 8.1.1. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний 8.1.1. “бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгээр 2024 онд ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь 8.45 хувийг эзэлж, 2025 онд 8.7 хувьд хүргэх зорилтоос 0.3 хувиар бага буюу өмнөх жилүүдийн өсөлтийн хувиар тооцоход 2025 оны зорилтот үр дүнд хүрэхээргүй байна.

27 Зорилт 3.6.Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

28 Зорилт 4.3 Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ

29 Зорилт 5.6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ

30 Зорилт 7.1.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ

31 7.4.Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ

32 Зорилт 7.5.Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцийг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ

33 Зорилт 7.1.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ

34 Байгалийн баялгийн үр өгөөж Зорилт 6.2.Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно

35 6.2.2.нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгоно

36 <https://epi.yale.edu/country/2024/MNG>

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 5 Тэргүүлэх чиглэлийн үр дүн 74.3 хувь, ТЭЗ-ийн үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 56.9 хувь, Хөтөлбөрийн үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 56.6 хувь, 194 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52.1 хувь байна.
2. Монгол Улсын 2024 оны үндэсний хэмжээний зарим статистик тоон мэдээлэл үзүүлэлт болон олон улсын байгууллагаас гаргадаг холбогдох тайланг гарах хугацаа болоогүйгээс шалтгаалж 3 тэргүүлэх чиглэл “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна”, “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна”, 3 ТЭЗ-ийн үр дүнгийн хүрсэн түвшин, биелэлтийг дүгнэх боломжгүй байна.
3. Засгийн газрын эрх бүхий байгууллагаас “ХБТТУТХ, МУИХХШТ хууль, холбогдох журамд заасан 15 хоногийн хугацаанд дунд шатны болон эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд цаг хугацааны, боловсон хүчний чадамж, зохион байгуулалт хангалтгүйгээс хуульд заасан зарчим, шаардлага, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.
4. Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зарим ТАХ-нд шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг оновчтой тодорхойлоогүй, Улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй, мөн хуульд заасан “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх” шаардлага, ХБТТУТХ-д заасан “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим”-ыг хангаагүй, зарцуулсан хөрөнгийг үнэн зөв, бодитой тайлагнаагүйгээс нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хөрөнгийн үнэ цэнийг бүрэн бий болгож чадаагүй байна.
5. ҮСХ-оос Улсын хэмжээний жилийн статистик тоон мэдээллийг харилцан адилгүй хугацааны давтамжтай тархааж байгаа нь ХБТТУТХ, МУИХХШТХ-д заасан цаглаварт хугацаанд бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг зөв тооцож үнэлэх боломжгүйд хүргэж байна.
6. Богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж боловсруулах үүрэгтэй ТЭЗ, ЭЗХЯ нь ХБТТУТХ-д заасан “бүх талын оролцоог хангах” зарчмыг баримтлаагүй, зарим төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөлгүй, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг оновчтой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй зөрчлүүд давтагдан гарч байгаагаас бодлогын хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй байна.
7. Богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах, бодлогын хувилбарыг урьдчилан төлөвлөж чадаагүй, салбарын онцлогт нийцсэн үзүүлэлт, индекс, гүйцэтгэлийн чанарын стандарттай нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалгүй нь тухайн салбарын бодлогын үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг тооцож чадахгүй байх эрсдэлтэй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль, журмын цаглаварт хугацаанд судалгаа, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах санал гаргах.
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолсон, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх.
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, олон улсын байгууллагаас тооцоолдог үзүүлэлтийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлттэй болох,
4. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг батлах.

Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолсон, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн зарчмыг хангаж төлөвлөх.
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, олон улсын байгууллагаас тооцоолдог үзүүлэлтийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлтийг боловсруулах,
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлэн төлөвлөж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гаргаж, бүх талын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх.
4. Засгийн газрын түвшинд хөгжүүлж буй "Их өгөгдлийн (big data) сан" мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй уялдсан улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийг эргэлтэд оруулах, эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй “Олон улсын үнэлгээний цогц систем” бүхий жишигт нийцсэн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.

Сангийн сайдад

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны баримт бичигт тусгасан бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардлагатай Улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх” шаардлагад нийцүүлэн тухайн жилийн төсвийг боловсруулах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт

1. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусган хүргүүлж байх,
2. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, Улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын төсвийн төсөлд хүргүүлэх саналд тусгаж байх,
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглэсэн, бүх талын оролцоог ханган боловсруулж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гарган хүргүүлж байх.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,
Цахим шуудан: info@ags.gov.mn,
Цахим хуудас: www.ags.gov.mn

2025.03.10 № 01/287
танай 2025.02.28-ны № 01/266 -т

Санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/866 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн 2.81 дүгээр заалтын 4 дэх хэсгийн “Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу УХЖТ-ний хэрэгжилтэд 15 хоногийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээг ЭЗХЯ болон ЗГХХГ-аас хийхдээ хүний нөөцийн чадамж, хүрэлцээ дутмаг, зохион байгуулалт хангалтгүй, цаг хугацааны нөлөөлөл, нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхгүй байгаа нь үнэн зөв бодитой үнэлэгдэхгүй байна” гэснийг “Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу ЭЗХЯ болон ЗГХХГ-аас Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд цаг хугацааны болон хүний нөөцийн хүрэлцээ дутмаг, улмаар нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүйгээс бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв, бодитой үнэлэгдэхгүй байна” гэж өөрчлөх;

2. Тайлангийн төслийн 2.88 дугаар хэсгийг “ЗГХХГ нь хөгжлийн бодлого болон дунд, богино хугацааны бусад бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг уялдуулан үнэлэх чиглэлээр олон улсын үнэлгээний цогц системийг нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд тус системд ҮСХ-ны “Төрийн нэгдсэн сан” (data.nso.mn) нэртэй өгөгдлийн сан дахь төрийн байгууллагын өгөгдөл, мэдээллийг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан ёсны өгөгдөл, тоон мэдээллийг төвлөрүүлэн ашиглах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.” гэж өөрчлөх;

3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний уялдаа холбоо хангалтгүйгээс бодлогын хэрэгжилт, үр дүнг тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хүрээнд харилцан уялдаатайгаар үнэлж, дүгнэх боломжгүй байгаа асуудлыг тайлангийн дүгнэлт хэсэгт нэмэлтээр тусгах;

4. Дүгнэлт хэсгийн 3 дугаар заалтыг “Засгийн газрын эрх бүхий байгууллагаас ХБТТУТ хууль, МУИХХШТ хууль, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд цаг хугацааны болон хүний нөөцийн

15160 0 0498

чадамж хангалтгүйгээс хуульд заасан зарчим, шаардлага, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж чадаагүй байна.” гэж өөрчлөх;

5. Тайлангийн зөвлөмж хэсэгт Монгол Улсын Засгийн газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт зөвлөмж болгох асуудлыг дараах байдлаар тусгах:

Монгол Улсын Засгийн газарт:

1) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн бодлого богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцсон, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх;

2) Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль журмын цагалбарт заасан хугацаанд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;

3) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлж, үүсч болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг батлах.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт:

1) Хяналт, үнэлгээний цогц системийг нэвтрүүлж, төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, мониторинг, үнэлгээний өгөгдлийг нэгдсэн платформ нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, бэлтгэл ажлыг хангах;

2) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, олон улсын байгууллагаас тооцоолдог үзүүлэлтийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлттэй болох;

3) Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн үе шатанд урьдчилсан үнэлгээ хийхтэй холбоотой журам, аргачлалыг баталж, мөрдүүлэх.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ӨНӨРБАЯР

Үндэсний аудитын газрын тайлбар:

ЗГХХГ-аас ирүүлсэн 5 санал, зөвлөмжид өөрчлөлт оруулах 6 санал нь аудитын тайланд дурдсан илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжтэй агуулгын хувьд нийцэж байгаа тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

ҮАГ-аас 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/866 дугаар “Аудитын тайлангийн төсөлд санал авах тухай” албан бичгийг ЗГХЭГ болон ЭЗХЯ-д хүргүүлсэн. ҮАГ-аас 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/866 дугаар “Аудитын тайлангийн төсөлд санал авах тухай” албан бичгийг ЗГХЭГ болон ЭЗХЯ-д хүргүүлсэн.

ЗГХЭГ болон ЭЗХЯ-аас Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэж заасан хугацаанд санал ирүүлээгүй тул мөн хуулийн 18.4-т “Шалгагдагч этгээд энэ хуулийн 18.2-т заасан хугацаанд аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй бол саналгүйд тооцно” гэсэн заасны дагуу саналгүй гэж үзлээ.

Хавсралтууд

Хавсралт 1. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Тэргүүлэх чиглэлийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл

д/д	УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” -нд тусгасан					тэргүүлэх чиглэлийн хүрсэн түвшин /ЗГ/	ЗГХХГ-ын үнэлгээ /хувиар/	Аудитын байгууллагын тодорхойлсон		
	Тэргүүлэх чиглэлийн нэр	тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	тэргүүлэх чиглэлийн суурь түвшин	тэргүүлэх чиглэлийн зорилтод түвшин			Хүрсэн түвшин	Үнэлгээ	
1	ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.	Экспорт	тэрбум ам.доллар	12.5	13.7	15.8	100	15.8	100	Үр дүнтэй
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.	Гадаадын хөрөнгө оруулалт	тэрбум ам.доллар	2.7	4	2.9	15.4	4	100	Үр дүнтэй
3	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.	Хүний хөгжлийн үзүүлэлт	эрэмбэ	96	92	96	0	-	Үнэлэх боломжгүй	
4	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ.	Хүлээн авах гадаад жуулчид	тоо (сая)	0.3	1.3	0.73	43	0.7	40	Эрчимжүүлэх шаардлагатай
5	ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛНА.	Хүнсний аюулгүй байдлын индекс	хувь	53.5	57.6	-	-	-	Үнэлэх боломжгүй	
6	УЛААНБААТАР ХОТЫН ТҮГЖРЭЛ, АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛНА.	Хотын хөгжлийн үзүүлэлт	оноо	0.6	0.6	0.5022	83.7	0.5022	83.7	Тодорхой үр дүнд хүрсэн
7	ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	эрэмбэ	108	100	-	-	-	Үнэлэх боломжгүй	
8	НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	эрэмбэ	155	130	143	48	143	48	Эрчимжүүлэх шаардлагатай

Хавсралт 2. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл

д/д	УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” -нд тусгасан					ТЕЗ-ийн үр дүнгийн хүрсэн түвшин /ЗГ/	Хэрэгжү үлэгч байгуул лагын үнэлгээ /хувиар/	ЭЗХЯ- ны үнэлгээ /хувиар/	ЗГХХГ- ын үнэлгээ /хувиар/	Аудитын байгууллагын тодорхойлсон		Хариуцагч байгууллага	
	ТЕЗ үр дүнгийн нэр	ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	ТЕЗ-ийн үр дүнгийн суурь түвшин	ТЕЗ-ийн үр дүнгийн зорилтод түвшин					Хүрсэн түвшин	Үнэлгээ		
1	1.1 Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Ачаа эргэлт	Сая тонн/км	17,572.7	26,944.8	24,500	90	73.9	73.9	33,992.7	100	Үр дүнтэй	ЗТЯ
2	1.2 Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадал	Сая тонн	50	80	103.19	100	100	100	103.14	100	Үр дүнтэй	Сангийн яам, ГЕГ
3	1.3 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт	Сая ам.доллар	380.6	506.6	391.9	77.4	9	8.97	423.8	84	Тодорхой үр дүнд хүрсэн	ХХААХҮЯ
4	1.4 Гадаад худалдааг хөнгөвчилнэ.	Уул уурхайн бус гадаад худалдаа /экспорт/	Мянган ам.доллар	859.9	1,000	2509.54	100	73.9	100	2013.55	100	Үр дүнтэй	Сангийн яам, ГЕГ
5	2.1 Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг 7-оор нэмэгдүүлнэ.	Тоо	-	7	5	70	70	71.4	0	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭЗХЯ
6	2.2 Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Уул уурхайн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин	Хувь	2.2	3	2.4	81	48.8	25	0	0	Үр дүнгүй	АҮЭБЯ
7	2.3 Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь	Хувь	81	83	88.8	100	100	100	73.1	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭХЯ
8	2.4 Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.4	0.8	0	0	0	0	0.4	40	Эрчимжүүлэх шаардлагатай	ССАЖЗЯ
9	2.5 Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангана	Хувь	5	10	10	100	100	100		70	Тодорхой үр дүнд хүрсэн	ШСАА/ОБАС/

10	3.1 Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээ	Хувь	72.9	75.8	70.22	92.6	0	92.6	69.5	40	Эрчимжүүлэх шаардлагатай	Боловсролын яам
		Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж	Хувь	36.6	41.6	36.6	100	0	100		Үнэлэх боломжгүй		Боловсролын яам
		Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж	Хувь	44.8	49.8	44.8	100	0	100		Үнэлэх боломжгүй		Боловсролын яам
		Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь	Хувь	58.8	61.2	63.6	100	100	100	63.6	100	Үр дүнтэй	Боловсролын яам
		Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь /их, дээд сургууль/	Хувь	69.8	71.9	72.5	100	100	100	72.5	100	Үр дүнтэй	Боловсролын яам
11	3.2 Нийгмийн баталгааг сайжруулна.	Төсвийн санхүүжүүлэх зардлын ДНБ-д эзлэх хувь	Хувь	3.6	3.3-аас бага	1.7			100	1.5	100	Үр дүнтэй	ГБХНХЯ
12	3.3 Өвчлөл, нас-баралтыг бууруулна.	Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	Продеци миль /10,000 хүнд, нэгжид ногдох үзүүлэлт/	32.5	26	38.4	0	0	0	38.4	0	Үр дүнгүй	ЭМЯ
		10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо	Продеци миль	973.9	779.1	95.1	100	100	100	95.1	100	Үр дүнтэй	ЭМЯ
13	4.1 Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Шинээр нэмэгдэх аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл	Тоо	-	4	100	100	100	100	4	100	Үр дүнтэй	ССАЖЗЯ

14	4.2 Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ.	4С ангилалд шилжүүлэх нисэх буудал	Тоо	1	5	1	30	0	25	0	0	Үр дүнгүй	ЗТЯ
15	4.3 Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Шинээр баригдах аялал жуулчлалын авто замын урт	Км	-	99.4	72.5	73	72..5	72.9	72.5	73	Тодорхой үр дүнд хүрсэн	ЗТЯ
16	5.1 Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	Гол нэр төрлийн 16 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамж	Хувь	92.8	95	-	100	100	-	-	Үнэлэх боломжгүй		ХХААХҮЯ
17	6.1 Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	Нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд /оргил ачааллын үед/	Км/ц	10	22	13	25	25	25	13	25	Үр дүнгүй	НЗДТГ
18	6.2 Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж	Мкг/м3	41	31	45	0	0	0	46	0	Үр дүнгүй	БОУАӨЯ
19	7.1 Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын индекс	Эрэмбэ	139	129	118	35.4	35.4	100	114	88.3	Тодорхой үр дүнд хүрсэн	ЗГХЭГ
20	7.2 Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө	Эрэмбэ	137	124	124	33.9	33.9	100		0	Үр дүнгүй	ЗГХЭГ
21	7.3 Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол	Тоо	904	600	1311	100	0	0	0	0	Үр дүнгүй	ХЭҮК
22	7.4 Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	Батлан хамгаалах чадавх	Хувь	70	72	72	50	50	100	71.6	50	Эрчимжүүлэх шаардлагатай	БХЯ
23	7.5 Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	Шүүхийн сахилгын хороонд гаргасан гомдлын тоо	Тоо	639	590	321	100	100	100	321	100	Үр дүнтэй	ХЗДХЯ
24	8.1 Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	155	130	143	48	50	48	143	48	Эрчимжүүлэх шаардлагатай	БОУАӨЯ

Хавсралт 3. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Хөтөлбөрийн үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл

д/д	УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” -нд тусгасан					Хөтөлбөрийн хүрсэн түвшин /ЗГ/	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ /хувиар/	ЭЗХЯ-ны үнэлгээ /хувиар/	ЗГХХГ-ын үнэлгээ /хувиар/	Аудитын байгууллагын тодорхойлсон			Хариуцагч байгууллага
	Хөтөлбөрийн үр дүнгийн нэр	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	Хөтөлбөрийн суурь түвшин	Хөтөлбөрийн зорилтод түвшин					Хүрсэн түвшин	Үнэлгээ		
1	1.1.1. Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ.	Төмөр замаар тээсэн экспортын ачаа	Сая тонн	27.7	60	45.2	75	54.2	54.2	19.3	20	Үр дүнгүй	ЗТЯ
		Төмөр замын сүлжээний урт	Км	2681	3147	3356.7	100	100	100	3743.9	100	Үр дүнтэй	ЗТЯ
2	1.1.2. Авто замын сүлжээг өргөтгөнө.	Улсын чанартай авто замын сүлжээнд хатуу хучилттай авто замын эзлэх хувь	Хувь	52	54	52.7	97.5	97.5	35	52.7	97.6	Тодорхой үр дүнд хүрсэн	ЗТЯ
3	1.2.1. Олон улсын жишигт нийцсэн боомтыг нэмэгдүүлнэ.	Инженерийн бүрэн хангамжтай боомт	Тоо	12	13	13	100	30	100	0	30	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭЗХЯ
4	1.3.1.Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг бий болгоно.	Үйлдвэрлэл, технологийн парк	Тоо	-	2	0	0	0	0	0	30	Эрчимжүүлэх шаардлагатай	ХХААХҮЯ
5	1.3.2. Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулна.	Малын гоц халдварт өвчний гаралт	Гоц халдварт өвчний гаралт	592	100	104	90	99.2	90	104	99.2	Тодорхой үр дүнд хүрсэн	ХХААХҮЯ
6	1.4.1. Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна.	Экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацаа	Цаг	302	72	72	100	100	100	31 цаг 54 минут	100	Үр дүнтэй	Сангийн яам ГЕГ
7	2.1.1. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлнэ.	Гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ	Тэрбум ам.доллар	2.5	4	2.9	72.5	26.7	26.7	2.9	72.5	Тодорхой үр дүнд хүрсэн	ЭЗХЯ
8	2.1.2. Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа	Хувь	13	20	22	100	0	0	16.2	81	Тодорхой үр дүнд хүрсэн	Монголбанк
9	2.1.3. Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.	Шинэчлэн байгуулсан хэлэлцээр	Тоо	2	6	5	90	90	75	0	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭЗХЯ

10	2.2.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ.	Нийт нутаг дэвсгэрт хайгуул хийсэн талбайн эзлэх хувь	Хувь	50	60	48	80	0	0		0	Үр дүнгүй	АҮЭБЯ
11	2.2.2. Зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ.	Ашиглагдаж байгаа стратегийн орд	Тоо	2	3	2	66.6	20	0	0	0	Үр дүнгүй	АҮЭБЯ
12	2.2.3. Боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.	Боловсруулах үйлдвэр /хүнд/	Тоо	60	70	54.8	77.8	54.8	0	0	0	Үр дүнгүй	АҮЭБЯ
13	2.3.1. Эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно.	Эрчим хүчний компаниудын санхүүгийн алдагдал	Тэрбум төгрөг	-5.7	-	-76	100	0	0	-76	29	Үр дүнгүй	ЭХЯ
14	2.3.2. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	Цахилгаан хангамжийн найдвартай байдлын үзүүлэлт	Исайди / Нэг хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа, цагаар/	18	9	5.6	100	100	100	16	29	Үр дүнгүй	ЭХЯ
15	2.4.1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.4	0.8	0	0	0	0	0.4	40	Эрчимжүүлэх шаардлагатай	ССАЖЗЯ
16	2.4.2. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1,000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал	Тоо	33.6	34.2	36.4	100	90	100	36.4	100	Үр дүнтэй	ССАЖЗЯ
17	2.5.1. Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	-	100	60	60	60	60	70	70	Тодорхой үр дүнд хүрсэн	ШСАА /ОБАЭ/
18	3.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийн тоог нэмэгдүүлнэ.	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувь	Хувь	1.3	3.9	1.4	50		3.8	1	29	Үр дүнгүй	Боловсролын яам
19	3.1.2. Дээд боловсролын судалгааг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Гадаадад хэвлүүлсэн импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	Тоо	743	906	720	100	100	79.5	499	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭЗХЯ
20	3.1.3. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Шинэ зохиогчийн эрхийн гэрчилгээ	Тоо	996	1,000	875	87.5	87.5	87.5	875	87.5	Тодорхой үр дүнд хүрсэн	ЭЗХЯ

		Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх цахим системд оруулах боть /материал/	Тоо	57/17159	60/18000	112/5750	100	100	70	112/5750	30	Эрчимжүүлэх шаардлагатай	ЭЗХЯ
		Шинэ бүтээл	Тоо	118	125	108	90	90	86.4	108	86.4	Тодорхой үр дүнд хүрсэн	ЭЗХЯ
		Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.13	0.2	0.1	50	0	0	0.02	29	Үр дүнгүй	ЭЗХЯ
21	3.1.4. Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.	Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь	Хувь	71	76	72	94.7	70	20	72.85	70	Тодорхой үр дүнд хүрсэн	Боловсролын яам
22	3.1.5. Сургуулийн өмнөх боловсролын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.	Сургалтын орчны стандарт хангасан цэцэрлэгийн хувь	Хувь	60	66	63	95.4	50	50	32	50	Эрчимжүүлэх шаардлагатай	Боловсролын яам
23	3.2.1. Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа	Хувь	33	33	32	100	100	100	29.4	89.1	Тодорхой үр дүнд хүрсэн	ГБХНХЯ
24	3.2.2. Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа	Харьцаа	0.9	0.9	0.9	93.3	100	93.3	0.84	93.3	Тодорхой үр дүнд хүрсэн	ГБХНХЯ
25	3.2.3. Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	Төрийн албанд зарласан сул орон тоо	Тоо	3,243	3,243-аас бага	3243	100	0	0	8697	30	Эрчимжүүлэх шаардлагатай	ТАЗ
26	3.3.1. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасан эмийн эзлэх хувь	Хувь	15.9	18.7	27.3	100	90	100	27.3	100	Үр дүнтэй	ЭМЯ
27	3.3.2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт	Хувь	64.9	67.5	0	0	0	-	0	0	Үр дүнгүй	ЭМЯ
28	3.3.3. Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хөдөлгөөний хомсдолтой 15-69 насны хүн амын эзлэх хувь	Хувь	21.9	17.5	29	100	100	0	29	0	Үр дүнгүй	ССАЖЗЯ

29	4.1.1. Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь	Хувь	7.2	8	6	75	0	0	6.8	0	Үр дүнгүй	ССАЖЗЯ
30	4.2.1. Нислэгийн тоог нэмэгдүүлнэ.	Нислэгийн тоо	Тоо	18,000	30,000	23,957	79	48.3	49.6	23957	49.6	Эрчимжүүлэх шаардлагатай	ЗТЯ ИНЕГ
31	4.3.1. Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын авто замын сүлжээний урт	Км	-	99.4	72.5	73	72.9	73	0	0	Үр дүнгүй	ТЯ
32	5.1.1. Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлнэ.	Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр нэмэгдүүлэх хувь	Хувь	-	80	100	100	0	0	90	90	Тодорхой үр дүнд хүрсэн	ХХААХҮЯ
33	6.1.1. Авто замын ачааллыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлнэ.	Түгжрэлийг бууруулсан хэмжээ	Хувь	-	8	0	0	0	0	0	0	Үр дүнгүй	НЗДТГ
34	6.1.2. Авто машингүй зорчих замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1,000 хүнд ногдох явган хүний зам	Км2	112	128	139.1	70	70	100	39.4	30	Эрчимжүүлэх шаардлагатай	НЗДТГ
		1,000 хүнд ногдох дугуйн зам	Км	0.1	0.1	7.3	30	30	100	0.09	90	Тодорхой үр дүнд хүрсэн	НЗДТГ
35	6.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Нийслэлийн нийтийн тээврээр зорчдог хүн амын эзлэх хувь	Хувь	34	56	41.9	74.8	35.9	35.9	33.6	60	Эрчимжүүлэх шаардлагатай	НЗДТГ
36	6.1.4. Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно.	Нийслэлийн авто замын үндсэн сүлжээний урт	Км	1,135	1207	1231.3	100	100	100	1231.3	100	Үр дүнтэй	НЗДТГ
		Авто замын уулзварын нэвтрүүлэх чадвар	Хувь	24	15	31	100	30	100			Үнэлэх боломжгүй	НЗДТГ
		Нийслэл дэх төмөр замын гарам	Тоо	172	168	171	25	25	25	171	25	Үр дүнгүй	НЗДТГ
37	6.2.1. Инженерийн дэд бүтцийн хүртээмж, найдвартай байдлыг дээшлүүлнэ.	Инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь	15	100	69.6	70	64.2	64.2	56.2	56.2	Эрчимжүүлэх шаардлагатай	ХББОСЯ
38	6.2.2. Гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулна.	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь	23	28	27	90	80	80	27	70	Тодорхой үр дүнд хүрсэн	НЗДТГ
39	6.2.3. Шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь	-	50	60	60	50	60	30	60	Эрчимжүүлэх шаардлагатай	НЗДТГ

40	7.1.1. Авлигын гэмт хэргийг бууруулна.	Авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эзлэх хувь	Хувь	71.9	67	59.9	100	100	0	59.9	29	Үр дүнгүй	АТГ
41	7.2.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/	Хувь	1.9	2.3	7,76	100	100	100	7.76	100	Үр дүнтэй	ЗГХЭГ ТӨБЗГ
42	7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	Төрийн үйлчилгээг цахимаар хүртэгчид	Мянган хүн	1,488	2,000	1947000	100	100	89.6	1947000	97.4	Тодорхой үр дүнд хүрсэн	ЦХИХХЯ
43	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс /НҮБ-ын цахим засгийн судалгаа/	Оноо	0.7	0.1	0.9	100	100	100	0.84	100	Үр дүнтэй	ЦХИХХЯ
44	7.2.4. Газрын харилцааны үйлчилгээг хялбаршуулна.	1,000 газар эзэмшигчид ногдох маргаан, зөрчил	Тоо	5.1	4.1	0	100	100	0	3.7	100	Үр дүнтэй	ЗГХЭГ
45	7.2.5. Эрэн хайх, аврах ажиллагааны чанарыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	60	100	100	100	90	100	100	100	Үр дүнтэй	ШСАА /ОБАЭ/
46	7.3.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдал хангагдана.	Нийт үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд, гэр бүлээс үйлчилгээ авсан хүүхэд, гэр бүлийн эзлэх хувь	Хувь	55	85	85	100	100	100	0	0	Үр дүнгүй	ХЗДХЯ
47	7.4.1. Цэргийн мэргэжил олгох сургалт болон Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.	Цэргийн мэргэжил олгох сургалтад оролцогчид	Хүн	500	2,000	1000 гаруй	90	33.3	33.3	1000 гаруй	70	Тодорхой үр дүнд хүрсэн	БХЯ
		Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчид	Хүн	120	1,000	900 гаруй	100	88.6	88.6	800 гаруй	90	Тодорхой үр дүнд хүрсэн	БХЯ
48	7.4.2. Хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.	Хил орчмын дэглэмийн зөрчил	Хүн/удаа	85/819	68/655	72/308	100	100	76.5	74/310	90	Тодорхой үр дүнд хүрсэн	ХЗДХЯ
49	7.5.1. Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг нэмэгдүүлнэ.	Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол	Тоо	21	17	21	100	0	0	21	0	Үр дүнгүй	ХЗДХЯ
		Давтан шинжилгээ	Тоо	549	440	628	100	70	0	628	0	Үр дүнгүй	ХЗДХЯ
50	8.1.1. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	7.7	8.5	8.48	100	100	97.5	8.45	99	Тодорхой үр дүнд хүрсэн	БОУАӨЯ
51	8.1.2. Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ	Хувь	10	12.5	12.6	100	90	100	85.36	100	Үр дүнтэй	БОУАӨЯ

52	8.1.3. Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлнэ.	Төслийн хэрэгжилт	Хувь	-	10	7	70	70	70	0	30	Эрчимжүүлэх шаардлагатай	БОУАӨЯ
		Тарималжуулсан ургамлын зүйл	Тоо	10	12	19	100	90	100	21	100	Үр дүнтэй	БОУАӨЯ
53	8.1.4. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.	Амьдрах орчныг тэтгэх арга хэмжээ авсан болон зориудаар өсгөн үржүүлсэн нэн ховор, ховор амьтны зүйл	Тоо	3	5	6	100	100	100	4 амьтан	80	Тодорхой үр дүнд хүрсэн	БОУАӨЯ

Хавсралт 4. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд батлагдсан Төсөл, арга хэмжээний үр дүнгийн хүрсэн түвшин, хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл

д/д	УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” -нд тусгасан					Төсөл, арга хэмжээний хүрсэн түвшин /ЗГ/	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ /хувиар/	ЗГХХГ-ын үнэлгээ /хувиар/	Аудитын байгууллагын тодорхойлсон			Хариуцагч байгууллага
	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	Төсөл, арга хэмжээн ий суурь түвшин	Төсөл, арга хэмжээний зорилтод түвшин					Хүрсэн түвшин	Үнэлгээ		
1	1.1.1.1.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан 18.9 км холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	20	50	40	70	70	10	30	Эрчимжүүлэх шаардлагатай	ЗТЯ
2	1.1.1.2.Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Төмөр замын урт	Км	-	10	0	30	30	30	0	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЗТЯ
3	1.1.1.3.Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/	Хүчин чадал	Сая тонн	30	54	32.4	60	10	30	33.4	61.9	Эрчимжүүлэх шаардлагатай	ЗТЯ
4	1.1.1.4.Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	5	0	30	30	30	2.5	50	Эрчимжүүлэх шаардлагатай	ЗТЯ
5	1.1.1.5.Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	10	0	30	30	30	0	10	Үр дүнгүй	ЗТЯ
6	1.1.2.1.Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	43.2	100	99.3	100	90	90	90	90	Тодорхой үр дүнд хүрсэн	ЗТЯ
7	1.1.2.2.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	0	50	0	30	30	0	0	29	Үр дүнгүй	ЗТЯ

“Улсын Хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл” аудитын тайлан

8	1.1.2.3.Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	10	0	30	30	0	0	0	Үр дүнгүй	ЗТЯ
9	1.1.2.4.Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	20	0	30	30	0	0	0	Үр дүнгүй	ЗТЯ
10	1.1.2.5.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	15	0	30	30	0	0	0	Үр дүнгүй	ЗТЯ
11	1.1.2.6.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Улиастай-Алтай чиглэлийн 42 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	15	0	30	30	0	0	10	Үр дүнгүй	ЗТЯ
12	1.2.1.1.Хилийн боомтуудад ухаалаг цахим гарц суурилуулах	Ухаалаг цахим гарц суурилуулах хилийн боомт	Тоо	0	14	10	100	100	90	10	70	Тодорхой үр дүнд хүрсэн	ХЗДХЯ
13	1.2.1.2.Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтуудыг иж бүрнээр өргөтгөн шинэчлэх	Боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалт	Хувь	0	25	0	30	30	30	6.8	29	Үр дүнгүй	Сангийн яам, БСҮХ
14	1.2.1.3.Хилийн боомтуудыг гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжөөр хангагдсан гаалийн шалган нэвтрүүлэх цэг	Тоо	-	16	5	30	30	30	3	40	Эрчимжүүлэх шаардлагатай	Сангийн яам, БСҮХ
15	1.2.1.4.Төмөр замын Эрэнцав боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	-	100	90	90	90	30	70	70	Тодорхой үр дүнд хүрсэн	ГХЯ
16	1.2.1.5.Цагаандэл-Уул хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх	Боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалт	Хувь	0	100	30	30	0	0	10	10	Үр дүнгүй	Сангийн яам, БСҮХ
17	1.3.1.1.Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Дэд бүтцийн бүтээн байгуулалт	Хувь	0	20	90	90	70	90	20	90	Тодорхой үр дүнд хүрсэн	НЗДТГ
18	1.3.1.2.Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Дэд бүтцийн бүтээн байгуулалт	Хувь	-	50	0	0	0	0	20	20	Үр дүнгүй	ХХААХҮЯ
